# ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015.12.31 Улаанбаатар хот

## Нэг: Дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн

### Хүний нөөцийг сонгон шалгаруулах, үнэлэх тогтолцоог боловсронгуй болгож, мэргэжлийн болон давтан сургалтын чанар үр дүнд ахиц гаргах гэсэн нэгдүгээр зорилтын хүрээнд:

Тус цагдаагийн хэлтэст 2015 онд төсөвт 50 офицер, 51 ахлагч, энгийн 8 ажилтан, нийт 109 ажилтан алба хаагч, ЦЕГ-ын даргын 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Б/205 тоот тушаал, Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэгтэй байгуулсан цагдаагийн алба хаагч ажиллуулах ХАГ/15/002 дугаар гэрээний дагуу 14 офицер 81 ахлагч нийт 95 алба хаагч бүгд 64 офицер, 132 цагдаа, 8 энгийн алба хаагч ажилтан бүгд 204 алба хаагч ажиллахаар батлагдсан.

2015 оны 09 дүгээр сарын 30 ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын даргын Б/476 дугаар тушаалаар тус цагдаагийн хэлтсийн Хэрэг бүртгэх мөрдөн байцаах тасгийн жинхэнэ 2 хэрэг бүртгэгчийн ажлын байр, цол, цалингийн зэрэглэлтэй нь Улаанбаатар хотын цагдаагийн газрын бүтцэд шилжүүлж, 202 алба хаагч, ажилтан ажил үүрэг гүйцэтгэхээс гэрээт төсөвт нийт цагдаа 3 орон тоо дутуу ажиллаж байна.

Монгол Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн гэрээний дагуу 95 алба хаагчийн цалин, хувцасны зардал, томилолт, сургалт, бичиг хэрэг, холбоо техник хэрэгсэл, шагнал урамшуулал болон бусад зардалд 1,229,946,939 төгрөгийг батлуулан хэлтсийн дансанд улирлаар шилжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс нь алба хаагчдын сургалт, хөгжлийн чиглэлээр 2015 онд зохиогдох албаны сургалтыг ЦБҮАЖ-ын код 117 буюу ЦЕГ-ын даргын 2010 оны 06 сарын 30-ны өдрийн 351 тоот тушаал, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2015 оны б/146 тоот тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2015 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу зохион байгуулав. Үүнд:

- Алба хаагчийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг 16 удаа 32 цаг зохион байгуулан 1367 алба хаагч
- Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 21 удаа 42 цаг зохион байгуулан 1872 алба хаагч
- Мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах сургалтыг 15 удаа 30 цаг зохион байгуулан 1290 алба хаагч
- Бие бялдрын бэлтгэлжилтийн сургалтыг 114 удаа 228 цагийн сургалтыг зохион байгуулан 627 алба хаагч хамрагдсан байна.

Дээрх сургалтуудыг зохион байгуулах ажлын хүрээнд сургагч багш болон тасгийн даргаас дээш албан тушаалтан хичээл заасан байдлыг авч үзвэл 19 удаа 38 цагийн сургалтыг зохион байгуулсан байгаа бөгөөд 1779 алба хаагч хамрагдсан байна.

2015 онд ажлын байран дахь сургалт зохион байгуулах ажлын хүрээнд

- Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцаа хандлага” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж,
- Хэлтсийн даргын баталсан “Хэрэг бүртгэх эрх бүхий албан хаагчдад явуулах албаны сургалтын төлөвлөгөө”, “Сахилга хариуцлага, харилцааны соёлоо дээшлүүлцгээе” удирдамжийн хүрээнд гаргасан сэтгэл зүйчийн багц сургалтын төлөвлөгөөний дагуу тус тус сургалтууд зохион байгуулж,
- Ажлын байранд зохион байгуулагдсан 19 хичээл сургалтыг алба хаагчдад файлаар тараан, хэлтсийн веб сайтанд байршуулж,
- Хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагчдын мэдлэг, чадварын түвшин тогтоох тест 1, эрх зүйн дээд боловсролтой алба хаагчдын мэдлэгийн түвшин тогтоох тест 2, ур чадварын түвшин тогтоох тест 2-ыг боловсруулж,
- Сургалтын зохиомол орчинг 3 удаа бүрдүүлж ажилласан байна.

Тус хэлтсийн алба хаагчдаас 2015 онд ЦЕГ-ын хэмжээнд зохион байгуулагдсан:

- Офицерын дамжаанд дадлагажигч эмч 2, цагдаагийн мэргэжлийн сургалтанд 2 алба хаагч
- ХСИС-ийн эчнээ сургалтанд 15 алба хаагч
- Магистрын сургалтанд 1 алба хаагч
- Докторын сургалтанд 1 алба хаагч
- Гадаад хэлний сургалтанд 4 алба хаагч
- Албан тушаалын сургалтанд 15 алба хаагч
- Бусад зорилтод сургалтанд 15 алба хаагч тус тус хамрагдсан байна.

Тус хэлтсийн хэмжээнд Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Баярбат, сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос, цагдаа, цагдаагийн ахлах ахлагч С.Одгэрэл нар сургагч багшаар ажилладаг.

Цагдаагийн ерөнхий газрын хэмжээнд зохион байгуулсан:

- ➢ Тус хэлтсийн дэд бөгөөд эрүүгийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Бирваа ЭЦГ-аас зохион байгуулсан Эрүүгийн тасгийн дарга нарын 3 хоногийн сургалтанд
- ➢ “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх арга зүй” сэдэвт 1 өдрийн сургалтанд Төлөвлөлт зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Баярбат
- ➢ Мөрдөн байцаах албаны удирдах ажилтаны 3 хоногийн сургалтанд Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа А.Лхагвадорж,
- ➢ Төв архивын газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй” сэдэвт 21 хоногийн сургалтанд бичиг хэргийн эрхлэгч, цагдаагийн ахлах ахлагч С.Гангармөрөн
- ➢ Англи хэлний анхан шатны сургалтанд цагдаа, цагдаагийн ахлах ахлагч С.Бат-Эрдэнэ, Н.Бат, цагдаагийн ахлагч О.Цэндсүрэн
- ➢ ЦЕГ-аас зохион байгуулсан гадаад хэлний сургалтанд цагдаа, цагдаагийн ахлагч С.Бат-Эрдэнэ, Н.Бат
- ➢ Сургагч багшийг чадавхижуулах сургалтанд орлогч, ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч С.Баярбат, сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос нар тус бүр 4 удаа

- Хууль сахиулах байгууллагуудын сэтгэл зүйчдийн сургалт зөвлөгөөнд болон ЦЕГ-ын сэтгэл зүйчдийн мэргэшүүлэх нэгдсэн сургалтанд сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос
- "Удирдлагын арга барил, манлайллыг дээшлүүлэх" сургалтанд ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Д.Түвшинтөр,
- Мөрдөн байцаах газраас зохион байгуулсан Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг мөрдөх ажиллагааны арга тактик сургалтанд мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч Г.Мөнхбат, Залилан мэхлэх гэмт хэргийг мөрдөх ажиллагааны арга тактик сургалтанд мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч Ж.Гэрэлт-Од
- ЦЕГ-ын Сургалтын төвөөс ирүүлсэн албан бичгийн дагуу 2015 онд сургалтанд хамрагдах 113 нэр бүхий алба хаагчийн нэрсийг хүргүүлж, 21 сэдвийн хүрээнд 48 алба хаагч сургалтанд хамрагдсан бөгөөд цагдаагийн хошууч Ц.Цэрэндорж, Э.Энхбаяр, Н.Хаянгарав, Г.Басбиш, цагдаагийн ахмад Г.Мөнхсайхан, Д.Өнөртөгс, Ц.Оюунбаяр, Г.Бишсүрэн цагдаагийн дэслэгч хэв журмын байцаагч, цагдаагийн ахмад Ц.Энхтайван, М.Ганзориг, цагдаагийн ахлах дэслэгч Т.Энхтүвшин, А.Багатамир, М.Хүрэлбаатар, цагдаагийн дэслэгч Э.Шинэхүү, Ч.Анхбаяр, С.Чинзориг, Э.Тулга, Ж.Гэрэлт-Од, Г.Мөнхбат, цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Г.Гантөмөр, Ц.Улсбаяр, Ш.Нямхүү, цагдаагийн дэд ахлагч Д.Анарбат, цагдаагийн ахлах ахлагч Д.Пүрэвдагва, Д.Дамба-Очир, Д.Эрдэнэчулуун, Ү.Ганхөлөг, Ц.Чимэдрэгзэн, С.Мандахнар, З.Нямрагчаа, П.Отгонсүрэн, Ж.Зоригт, цагдаагийн дэд ахлагч Э.Ганбаатар нарын алба хаагчид тус тус хуваарийн дагуу хамрагдсан байна.

Түүнчлэн 2016 онд боловсролын зэрэг болон мэргэшүүлэх сургалтанд хамрагдах хүсэлтэй 15 алба хаагчийн нэрсийг ЦЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж ажиллажээ.

Түүнчлэн ЦЕГ-ын Сургалт дадлагын төвд сургагч багш, Төлөвлөлт зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Баярбат нь 4 удаагийн 16 цагийн, сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос 10 удаа 42 цагийн сургалтыг тус тус батлагдсан хуваарь сэдвийн дагуу орж, ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын баталсан удирдамжийн дагуу "Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага" сэдэвт модуль сургалтын багт орж 4 удаа 32 цагийн сургалт орсон байна.

Төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн хэмжээнд алба хаагчдын хууль эрх зүй, албаны мэдлэг чадвар зэвсэг техник, бие бялдар, харилцаа, сахилга ёс зүйг дээшлүүлэх зорилгоор Даваа, Пүрэв гаригийг сургалтын өдөр болгон хэвшүүлж, сургалтыг зохион байгуулж, офицер бүрэлдэхүүн дангаар, ахлагч бүрэлдэхүүн багаар мэдээлэл хийх хуваарь гарган хэлтсийн даргаар батлуулан, мэдээлэл хийж хэвшсэн.

ЦЕГ-ын Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс нь албаны сургалт явуулах суурин микрофон 12, проектор, 6 x 6 дэлгэц бүхий иж бүрэн тоноглогдсон танхимтай болно.

Ажлын байран дахь сургалтын 25 хувийг цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй, харилцааг дээшлүүлэх чиглэлийн сургалтууд зохион байгуулснаар харилцаа, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын тоо өнгөрсөн оны мөн үеийнхнээс 15%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Түүнчлэн нийт сургалтын 27 хувийг сэтгэл зүйн болон эерэг хандлага төлөвшүүлэх, амьдралын зөв хэвшлийн сургалтууд эзэлж байгаа бөгөөд алба хаагчдын стрессын түвшин буурч, стресс тайлах энгийн арга техникуудийг эзэмшин, нийт бүрэлдэхүүний 65% нь дугуй, бялдаржуулах урлаг, ууланд аялах спортоор хичээллэн амьдралын зөв хэвшил дадалтай болжээ.

**Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах ажлыг шинэ шатанд хүргэх гэсэн хоёрдугаар зорилтын хүрээнд:**

**Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

Байгууллагын нууцыг тогтоох, хамгаалах ажлын хүрээнд хэлтсийн даргын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/31 тоот тушаалыг гарган, орон тооны бус ажлын хэсгийг байгуулан, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж ажлын хэсгийн гишүүдээс нууцын баталгаа гаргуулан авсан. Дотоод аюулгүй байдлын орон тооны бус ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь байгууллагын аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, санхүүгийн аюулгүй байдлыг хангах, галт зэвсэг, тусгай хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах гэсэн нийт 7 чиглэлээр хяналт, шалгалт явуулахаар графикт тусгасан. ЦЕГ-ын Төв архивын газрын Тусгай архивт цагдаагийн хэлтсийн нууц баримт бичгийн 2015 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг ЦЕГ-ын даргын 2015.05.28-ны өдрийн МН-1/79 дүгээр тушаалаар батлагдсан “Нууцын зэрэглэлтэй баримт бичиг, биет зүйлийг хамгаалах журамд”-д заасны дагуу шинэчлэн гаргаж, нууцын байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг нууц баримт бичиг нягтлан шалгах комиссын 2015 оны 9-р сарын 22-ны өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн хурлын тэмдэглэлийн хамт ЦЕГ-ын Төв архивын газарт хүргүүлэн ЦЕГ-ын дэргэдэх нууц баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хуралд танилцуулж батлуулав. Мөн нууцын байнга, 60 жил хадгалагдах хадгаламжийн 1999-2012 оны 39 хн-ийг нөхөн бүрдүүлэлтээр тусгай архивт шилжүүлэв.

**2. Хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Тус цагдаагийн хэлтсийн алба хаагчдыг дэвшүүлэн томилуулах, суралцуулах, шагнах тохиолдолд ажлын үр дүнг сүүлийн 3 жилээр үнэлэн В болон түүнээс дээш үнэлэгдсэн, сахилга ёс зүйн зөрчилгүй алба хаагчдыг сонгон тэднийг дэмжин ажиллаж байна. 2015 оны байдлаар 3 алба хаагчийг дэвшүүлэн, 3 алба хаагчийн ажлын байрыг өөрчлөн томилуулсан байна. Цагдаагийн албанд анх орох иргэний сонгон шалгаруулалтыг ЦЕГ-аас зарласны дагуу төрийн тусгай албанд анх орох болон дахин орох хүсэлт гаргасан алба хаагч, иргэдийг судлан шаардлага хангасан иргэдийн материалыг ЦЕГ-т хүргүүлэн ажилладаг. 2015 оны байдлаар 6 иргэний материалыг хүргүүлсэн ба 3 иргэн шалгалтанд тэнцээд байна. Тус цагдаагийн хэлтэст шилжин ажиллах хүсэлт гаргасан 12 алба хаагчийн хүсэлтийг хүлээн авч судлан тухай бүрт хариуг өгч ажиллав. 2015 оны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг бүтэн жилээр хийн ЦЕГ-т хүргүүлсэн. Шинээр томилогдон ажиллаж байгаа алба хаагчидтай тогтвор суурьшилтай ажиллах зорилгоор алба хаах гэрээг байгуулан ажиллаж байна. Шинээр томилогдсон 4 алба хаагчид дадлагажуулагч багш томилон сар бүр үр дүнг тооцон ажиллаа. 7 хоног

бүрийн Мягмар, Пүрэв гаригуудад Цагдаагийн байгууллагын сахилгын дүрэм, ЦБ-ын үйл ажиллагааны журам, хууль тогтоомжийн талаар алба хаагчдад тогтмол сургалт зохион байгуулж байна. Сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдад тухай бүр албаны шалгалт хийн хариуцлага тооцон ажиллаж байна. Одоогийн байдлаар 27 албаны шалгалт хийгдсэн байна. Ахлагч бүрэлдэхүүний хувийн хэргийг тусгай зориулалтын сейфэнд хийж хувийн дугаартай лац тэмдэг даран хадгалж байна. Алба хаагч бүрийн нэртэй хувийн хэргийн хавтсанд хийн хувийн хэрэгтэй танилцсан тухай бүртгэл хөтөлдөг.

**3. Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Тус цагдаагийн хэлтсээс 2015 онд давхардсан тоогоор нийт 3500 алба хаагчид алба хаагч аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар сургалтыг зохион байгуулан, зааварчилгаа өгч алба хаагчдад танилцуулан ажил үүрэг гүйцэтгэх томилгоот алба хаагч бүрт танилцуулан гарын үсэг зуруулж биелэлтэнд хяналт тавьж ажиллаа. Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс албаны дүрэмт хувцастай явуулахгүй байхаар зохицуулалт хийн алба хаагчдын хувцасны шүүгээг 2014 онд шийдсэн. Алба хаагчид суудлын галт тэргэнд 2, 2-оор үүрэг гүйцэтгэж байна.2015 онд гэнэтийн ослын даатгалд даатгуулах 102 /төсөвт/, 93 /гэрээт/ нийт 195 алба хаагчдын даатгалд даатгуулахаас ЦЕГ-аас төсвийн 102 алба хаагчийг гэнэтийн ослын даатгалд МИГ даатгал ХХК-д даатгуулсан. 2015 оны 3 дугаар сард нийт алба хаагчдаас албан үүрэг гүйцэтгэснийхээ төлөө бусдаас хээл хахууль, шан харамж авахгүй, бусдын нөлөөнд автахгүй ажиллах баталгааг бичгээр гаргуулж авсан. Цагдаагийн алба мөнгөн урамшуулал олгох журмын дагуу 2014 онд авах байсан нэг /Г.Ганбат-Замын Үүд сум/ алба хаагчид 5.901.163 төгрөгийн урамшуулал олгосон. Сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос 1-р салааны 29 алба хаагч, 2-р салааны 10 алба хаагч, 3-р салааны 25 алба хаагч, нийт 64 алба хаагчийн ар гэрээр орж амьдралын түүхийн судалгаа хийв. Сахилга хариуцлагын зөвлөлгөөнийг улирал бүр зохион байгуулан, сахилга ёс зүйн зөрчлийг хамт олны дунд хэлэлцэж байна. Дээд газраас ирүүлсэн алба хаагчдын сахилга хариуцлагатай холбоотой албан бичгүүдийг тухай бүр алба хаагчдад танилцуулан сургалт зохион байгуулж байна. 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хэлтсийн даргын №27/01 тоот албан даалгаврыг хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарт танилцуулсан. Сар бүр хэлтсийн алба хаагчдын гэмт хэрэг болон захиргааны зөрчилд холбогдсон эсэх талаар цагдаагийн байгууллагын нэгдсэн сангаас мэдээлэл судалгааны алба хаагчид шүүж, хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Г.Баярцэцэг Дотоод хяналт аюулгүй байдлын мэдээллийн санд баяжуулалтыг хийдэг.

Зорчигч үйлчилгээний төв буудалд болон суудлын галт тэргэнд үүрэг гүйцэтгэх алба хаагчид, явуулын эргүүлүүдэд өдөр бүр хоногийн нөхцөл байдлын мэдээг танилцуулсны дараа агсамж болон нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж байгаад үзлэг шалгалт хийж Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрмийн 7-р зүйлд заасны дагуу алба хаагч өөрт ноогдсон үүргийг биелүүлэх, албаны бэлэн байдлыг хэрхэн хангаж байгааг шалгах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн түргэн цугларалтыг 6 удаа авч жагсаалын үзлэг шалгалт хийж зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулсан. Хэлтсийн ерөнхий эргүүлээр тасгийн дарга, ахлахуудыг томилон, тухайн өдрийн жижүүрийн бүрэлдэхүүн, жижүүр, эргүүл болон суудлын галт тэргэнд үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан артерын даралтыг үзүүлж, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг драйгераар шалгуулан ажил үүргийг нь гүйцэтгүүлэх, албаны автомашины цаг ашиглалтын дэвтэрт ерөнхий эргүүлүүд тогтмол хяналт тавьж, өдөр тутам хэлтсийн даргад танилцуулж хэвшсэн.

**4. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудал, Замын-үүд өртөө, Чойр өртөө, Зүүнхараа өртөө, Сэлэнгэ өртөөний цагдаагийн хэсгийн өрөөний цагдаагийн ерөнхий газрын сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна. Мэдээлэл холбоо, технологийн бодлого, журамд заасны дагуу хэлтсийн дотоод сүлжээний хэвийн ажиллагааг хангаж сүлжээний доголдолгүй, байнгын ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Хэлтсийн алба хаагчдын компьютерт паспортыг хийлгэж албаны файлуудыг он, сар, өдрөөр нь цэгцлүүлж мэдээллийн аюулгүй байдлыг хангаи ажиллаж байна. Хэт богино долгионы радио холбоонд ашиглагддаг радио торны нэр дуудлага, удирдлагаас өгөх команд харилцах кодын нууцлалыг хангаи ажиллаж байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Гэмт хэрэг зөрчлийн гомдол, мэдээлэл хүлээн авах" /код 202/ журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр Мэдээлэл Технологийн Төвийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Д.Мөнхзул, Мэдээлэл Технологийн Төвийн сургалт хариуцсан инженер, цагдаагийн ахлах дэслэгч Б.Сансартуяа нар, Гэмт хэргийг цахим зураглалд байршуулах талаар 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Мэдээлэл Технологийн Төвийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Баяндүүрэн нар алба хаагчдад тус тус сургалтууд зохион байгуулсан. Дотоод хяналт, аюулгүй байдлын цахим сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулж аюулгүй байдлын чиглэлүүдээр бүртгэлүүдийг оруулж , нийт 93 алба хаагчийн бүртгэл , захиргааны зөрчил гаргасан 70 албан хаагч, албаны шалгалт явуулсан тухай 65 албан хаагчийн мэдээллүүдийг тус тус цахимд оруулан, хэлтсийн дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Бирваа хяналт тавин ажиллаж байна.

**5. Санхүүгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актуудын хүрээнд төсвийг батлуулан, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, өр , авлага үүсгэхгүй байх, бүтэн жил, хагас жил, улиралын тайлангийн хуралд санхүү, аж ахуйн албаны хийсэн ажлын талаар алба хаагчдад тайланг танилцуулан ажилласан. Санхүү төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, түүнийг зориулалтын бусаар зарцуулах, ашиглах, завших, үрэгдүүлэхээс сэргийлэхэд чиглэсэн дотоод хяналтыг сайжруулахад анхаарч удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Цагдаагийн ерөнхий газрын даргын А/71 дүгээр тушаалаар баталсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Шийтгэвэр, торгуулийн хуудас зэрэг тооцооны хуудсаар хангах хадгалах, олгох, зарцуулах, тооцох бүртгэх /код-812/ журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчтай үнэт цаас, торгууль, шийтгэвэрийн тооцоо, үлдэгдэлгүй байна. Бүртгэлийн дэвтэр бусад тооцоот маягт, хөтлөгдөх ёстой маягтыг хөтлөн ажилласан ба Үнэт цаасны тооцоогоо хийхдээ Торгуулийн тасалбарын үлдэгдлийн дэлгэрэнгүй бүртгэлийг офицер /1,2 дугаар салааны цагдаа нарын тасалбарыг салаан даргад, зангилаадын цагдаагийн үнэт цаас, тасалбарыг салаан дарга нарт, шийтгэврийг офицер тус бүрээр хөтөлж, үлдэгдлийг баталгаажуулан сар бүрийн эцэст тайлан тооцоог гаргаж Санхүү, Ар талын газарт тайланг өгч, орлогыг тулгаж тооцоогүй ажиллаж байна. Салаан дарга, офицерууд торгуулийн хуудас, шийтгэвэрийн баримтыг

санхүүдээ өгөхдөө жагсаалт гарган, няравт тушаасан орлогын баримтын 1%, тасалсан тасалбарын хамт нягтлан бодогчид хүлээлгэн өгч үлдэгдлээ баталгаажуулан гарын үсэг зуран дараагийн тасалбараа авч хяналттай ажиллаж байна.

**6. Галт зэвсэг, тусгай хэрэгслийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Хэлтсийн галт зэвсэг хадгалах зориулалтын өрөө гаргаж, камержуулан Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, жижүүрийн ахлах зохицуулагчид өдөр бүр биеэр болон хяналтын камераар хянан ажиллаж байна. Сургалт, буудлагын тэмцээнд оролцсон алба хаагчдад ПМ сум, 7,62 сум 43268 төгрөгийн 80 ш сум олгосон.

ЦЕГ-аас хуваарилсан 9 нэр төрлийн 540 ширхэг 14.180.160 төгрөгийн тусгай хэрэгслийг алба хаагчдад хуваарилан олгосон. Алба хаагчдын гар дээр байгаа ашиглах боломжгүй болсон гав-112 ш, резинэн бороохой-54 ш, цахилгаан бороохой-100 ш , энгэрийн камер-35 ш, гар станц-24 ш, станцны чихэвч-8 ш, бамбай-2 ш, дуулга-3 ш, гар чийдэн-36 ширхгийг тус тус ЦЕГ-н Санхүү хангамжийн газраар актлуулж, нөхөн хангалтаар гав-60 ш, резинэн бороохой-80 ш, цахилгаан бороохой-60 ш, нэг удаагийн хэрэглээний гав-200 ш, нулимс асгаруулагч-60 ш, хутганаас хамгаалах бээлий-60 ш, хутганаас хамгаалах хантааз-20 ширхгийг тус тус хүлээн авсан. Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдыг нэг бүрийн тусгай хэрэгслээр хангасан ба Хэв журмын ажил хариуцсан байцаагч албаны сургалтын танхимд 7 хоног бүрийн Пүрэв гарагт албаны бэлтгэл болон нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх дадлага сургуулилтыг зохион байгуулж шинээр тавигдсан нэг удаагийн гавыг хэрхэн хэрэглэх сургалтуудыг тус тус орсон.

**7.Барилга байгууламж /объект/-ийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Хэлтсийн төв байрны болон саатуулах байрны хяналтын камерын хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна. 7 хоног тутамд үзлэг үйлчилгээ хийж байна. Улаанбаатар төмөр замын удирдах газрын харуулын салаан дарга Л.Сэргэлэнбат 2015.04.02-нд цагдаагийн хэлтсийн нийт бие бүрэлдэхүүнд 2 удаа галын тоноглол, галын хортой хэрхэн ажиллах,гал түймэр гарсан тохиолдолд өмч хөрөнгийг хэрхэн аврах чиглэлээр сургалт зохион байгуулж сургалтанд 126 алба хаагч хамрагдсан. Хэлтсийн төв байранд гал түймрийн эрсдэл бий болсон нөхцөлд ажиллах төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан давхар бүрт ил харагдахаар схем зураг байрлуулсан. Улаанбаатар төмөр замын гал унтраах ангиас манай байгууллагыг хариуцсан удирдах газрын харуулын салаан дарга Л.Сэргэлэнбаттай хамтарсан шалгалт хийн цэнэглэх шаардлагатай 7 ширхэг МПЗ хорыг цэнэглүүлсэн. Цагдаагийн хэлтсийн өргөтгөлийн 1,2,3-р давхарт цахилгааны монтажийг шинэчлэн хийлгэсэн. Хэлтсийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус гишүүдийн хамт үзлэг шалгалт хийн ажиллаж байна. Цагдаагийн хэлтсийн барилгын цахилгаан хангамж дотор гэрэлтүүлэг, цуглуулах самбаруудын холболт муудаж иж бүрэн засварын ажлыг эрх бүхий байгууллагаар зургийг боловсруулж, мэргэжлийн байгууллагаар угсралтын ажлыг хийж гүйцэтгүүлэх шаардлагатай тул 2015.11.30-ны өдрийн 02-07-103/2009 тоот мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гаргуулав.

**Удирдах ажилтны манлайлал, үүрэг хариуцлагыг сайжруулах гэсэн гуравдугаар зорилтын хүрээнд:**

Цагдаагийн ерөнхий газраас 2015 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус цагдаагийн хэлтэст хэрэгжүүлэх 36-н ажил, өөрийн байгууллагын ажлын онцлогтой уялдуулан 51-н ажил, цагдаагийн байгууллагын стратегийн зорилтын хүрээнд 7 бүлэг, 87 заалттай ажлыг төлөвлөж ЦЕГ-ын ГХТГ-ын даргаар батлуулан биелэлт үр дүнг тооцон ажиллаа.

Байгууллагын тасаг, алба хаагчдад ажил үүргийн онцлог, төрөл, мэргэжлийн онцлогийг нь харгалзан хувиарлан хариуцуулж биелэлтийг нь хугацаанд нь хэрэгжүүлсэн эсэхийг тооцож явц, үр дүнг цагдаагийн хэлтсийн даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлж хариуцсан дарга нарыг үүрэгжүүлж хэвшсэн.

**Алба хаагчдаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний шуурхай байдал, харилцааны соёл, ёс зүйг дээшлүүлэх гэсэн дөрөвдүгээр зорилтын хүрээнд:**

Цагдаагийн хэлтсийн бие бүрэлдэхүүний дунд харилцааны ур чадварыг сайжруулах чиглэлээр “Гэр бүлийн харилцаа” сэдвээр “MCS” группын сэтгэл зүйч Г.Одгэрэл яриа хийж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, ёс зүй, харилцааны соёлыг төлөвшүүлэх талаар зөвлөмж өгч ажиллаа.

Цагдаагийн хэлтсийн алба хаагчид бие бялдарын өв тэгш хүмүүжил, тэсвэр хатуужил, дайчин чанар олгох, тэднийг идэвхижүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 38 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын /код 939/-ын дагуу 2015 оны соён гэгээрүүлэх ажлын болон соён гэгээрүүлэх ажилд оролцох алба хаагчдын хуваарийг хэлтсийн даргын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/05 тоот тушаалаар батлан 10 төрлийн арга хэмжээг зохион байгуулж, эхний 3 байрт шалгарсан багуудыг шагнаж урамшууллаа.

2015 оны хичээл сургалт, соён гэгээрүүлэх ажлын нээлтийг нийтийн хэв журам хамгаалах тасгийн “Цасны баяр”-аар эхлүүллээ. Алба хаагчдын хамтач уур амьсгал, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхээр “Гар бөмбөг”-ийн тэмцээн, “Караоке” дууны тэмцээн, “Сагсан бөмбөг”, “Би иргэнлэг цагдаа” илтгэлийн тэмцээн, Буудлагын тэмцээн, Боулингийн тэмцээн зэргийг хуваарийн дагуу зохион байгуулав. Хэлтсийн нийт алба хаагчдын дунд төрийн шагналт, улс төрч, нийтлэлч Б.Баабар “Цагдаагийн байгууллагын хөгжил” сэдвээр 2 цагийн уулзалт ярилцлага зохион байгууллаа. 7 хоног бүрийн Даваа, Пүрэв гаригт хуваарьт алба хаагчид бие бүрэлдэхүүнд мэдээлэл хийн хэвшсэн бөгөөд одоогийн байдлаар 48 алба хаагч мэдээлэл хийгээд байна.

## Хоёр: Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Цагдаагийн төв байгууллагын даргын болон аймаг, нийслэл, дүүргийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 16 заалт бүхий салбар төлөвлөгөө, Цагдаагийн ерөнхий газраас биелэлт үр дүн тооцох, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх 39 баримт бичгийн жагсаалтыг гарган төлөвлөгөө боловсруулан биелэлт үр дүнг тооцон зохих байгууллагуудад хүргүүлсэн, Цагдаагийн байгууллагаас 2015 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажлын арга барилыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүний сахилга, ёс зүйг дээшлүүлэх, тэдний дунд зохиох сургалт, соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор 87-н заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан биелэлтийн гүйцэтгэлийг хангуулан ажиллаа.

МУ-ын Хууль зүйн сайдын А/248 дугаар архидан согтуурахтай тэмцэх тушаалыг хэрэгжүүлэх ЦЕГ-ын даргын 01/06 дугаар үүргийг хэрэгжүүлэх ажлын 7-н заалттай төлөвлөгөө, Хууль зүйн сайдын 2015 оны 02 сарын 06-нд өгсөн үүргийг хэрэгжүүлэх 8-н заалттай төлөвлөгөө, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2015 оны 02-р сарын 06-ны өдрийн өгсөн үүргийг хэрэгжүүлэх 32 заалттай төлөвлөгөөг тус тус боловсруулан, ЦЕГ-ын дэд даргын 01/467 тоот ажлын чиглэл, ГХТГазрын даргын 5/1250 албан даалгаварын хэрэгжилтийн явцыг тогтоосон хугацаанд тайлагнахаар ажиллахын зэрэгцээ бие бүрэлдэхүүний дунд хамт олонч уур амьсгалыг өрнүүлэх, бие биендээ зүй ёсны шаардлага тавьдаг, иргэдийг хүндэлдэг, үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд шударга байх зарчмыг баримтлан ажиллаж хэвшлээ.

## Гурав: Удирдлагын манлайлал, үйл ажиллагааны төлөвлөлт, тэдгээрийн хэрэгжилт, Цагдаагийн төв байгууллагын даргын үүрэг, зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, үр дүн

Цагдаагийн ерөнхий газраас 2015 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус цагдаагийн хэлтэст хэрэгжүүлэх 36-н ажил, өөрийн байгууллагын ажлын онцлогтой уялдуулан 51-н ажил, цагдаагийн байгууллагын стратегийн зорилтын хүрээнд 7 бүлэг, 87 заалттай ажлыг төлөвлөж ЦЕГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаа.

Байгууллагын тасаг, алба хаагчдад ажил үүргийн онцлог, төрөл, мэргэжлийн онцлогийг нь харгалзан хувиарлан хариуцуулж биелэлтийг нь хугацаанд нь

хэрэгжүүлсэн эсэхийг тооцож явц, үр дүнг цагдаагийн хэлтсийн даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлж хариуцсан дарга нарыг үүрэгжүүлж хэвшсэн.

Тус цагдаагийн хэлтсийн даргын дэргэдэх зөвлөлийн хурал 2015 онд 20 удаа хуралдсан байна. 2015 оны 01 дүгээр сард офицер бүрэлдэхүүнд орох, ахлах болон түүнээс дээш албан тушаалын нөөцөнд авч 10 алба хаагчийн нэрсийг хүргүүллээ. Хэлтсийн гэрээт 95 алба хаагчийн бүтэц орон тоог батлуулахаар саналаа ЦЕГ-ын Хүний нөөц сургалтын хэлтэст уламжлан ЦЕГ-ын даргын 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Б/205 тоот тушаалыг гаргууллаа. Тус цагдаагийн хэлтэст шилжин ажиллах хүсэлт гаргасан 5 алба хаагчийн, офицер бүрэлдэхүүнд орох 2 алба хаагчийн, албан тушаал өөрчлөх хүсэлт гаргасан 2 алба хаагчийн, хөдөө орон нутагт тасралтгүй 60 сар ажиллаж 30 сарын цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн мөнгөн урамшуулал авах хүсэлт гаргасан 2 алба хаагчийн материалыг хүргүүлэн шийдүүлээд байна. Хэлтсийн 3 өндөр настанд тус бүр 100,000 төгрөгний буцалтгүй тусламж олголоо.

**Дөрөв: Үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, мэдээллийг тайлагнах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн**

Цагдаагийн хэлтсийн 2014 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлсэнийг төв байгууллагаас үнэлж дүгнэн 03 дугаар сард байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн цаашид анхаарах асуудлын санал зөвлөмж ирүүлсэнийг биелүүлэх “Гүйцэтгэл сайжруулах 12 заалт бүхий төлөвлөгөө” боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

2015 оны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх шинэчлэгдсэн журмын дагуу 39 баримт бичгийн жагсаалтыг хийж, төлөвлөгөө боловсруулан үр дүнг тооцон тайланг бичиж хугацаанд нь хүргүүлж ажиллаа.

**Тав: Шүүх прокурорын мэдэгдэл, энгийн магадлалын дагуу авсан арга хэмжээ, үр дүн**

Цагдаагийн хэлтсийн алба хаагчдаас 2015 оны эхний байдлаар мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагчдын хуулийг хэрэглэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор албаны сургалтуудыг явуулж, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчиж прокурорын мэдэгдэл шаардлага аваагүй байна.

**Зургаа: Гэмт хэрэг, зөрчлийн талаархи гомдол мэдээлэл**

**Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаархи гомдол мэдээлэл**

1.1. <u>Хүлээн авч шалгасан нийт гомдол мэдээлэл:</u>
- 781 гомдол мэдээлэл шалгасан: Үүнд эрүүгийн албанаас эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар 25, харъяаллын дагуу 7,




Нийт 762 гомдол мэдээлэл шийдвэрлэснээс

- 358 буюу 47 хувийг гэмт хэргийн,
- 45 буюу 6 хувийг бусад ,
- 8 буюу 1 хувийг харъяаллаар шилжүүлж,
- 351 буюу 46 хувийг зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна.

1.2. <u>Гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал:</u>

- 100 буюу 28 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн,
- 257 буюу 72 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан, тэдгээрээс гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлтэй 253,
- 1 гомдол мэдээллийг 0,3 хувийг нэгтгэсэн байна.

1.3. <u>Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа:</u>

- 189 буюу 53 хувийг 5 хоногт,
- 169 буюу 47 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна.

1.4. <u>Зөрчлийн талаархи гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал:</u>

- 298 буюу 85 хувийг шийтгэврээр торгож,
- 8 буюу 2,2 хувийг баривчилж,
- 1 буюу 0,3 хувийг торгуулийн хуудсаар,
- 6 буюу 1,7 хувийг зөрчлийг хянан шалгаж шийдвэрлэх боломжгүй үндэслэлээр,
- 38 буюу 10,8 хувийг жолоодох эрх хасаж шийдвэрлэсэн.

1.5. <u>Нийт зөрчлийн талаархи гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа:</u>

- 308 буюу 88 хувийг 14 хоногт,
- 43 буюу 12 хувийг 15-28 хоногт шийдвэрлэсэн байна.

1.6 <u>Бусад шийдвэрлэлт</u>:

-26 гомдол, мэдээллийн дуудлага худал байсан,

-1 гомдол, мэдээлэлд зөвлөгөө өгсөн,

-18 гомдол, мэдээллийг газар дээр нь зохицуулсан үндэслэлээр шийдвэрлэсэн байна.

## Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг

<u>2.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг</u>

- Хэлтсийн хэмжээнд 12 сард 85 гэмт хэрэг бүртгэгдсэн. Энэ нь өмнөх оны мөн үеэс 13 буюу -13,3 %-аар буурсан байна.

<u>2.2. Гэмт хэргийн ангилал өсөлт, бууралтаар:</u>




## 2.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн төрлөөр:




## 2.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн гариг:




## 2.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг:




2.6. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал

- Нийт гэмт хэргийн 21 нь согтуугаар, хүүхэд оролцсон 6, эмэгтэй хүн оролцсон 27, гэр бүлийн хүчирхийллийн улмаас 1, бүлэглэн гүйцэтгэсэн 8 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

2.7. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар




- Гудамж талбайд 5 үйлдэгдсэний 3 нь төмөр замын орчинд, 1 нь ил зогсоол дээр

- Олон нийтийн газар 22 үйлдэгдсэний 14 нь төмөр замын буудал дээр,

- Нийтийн тээвэрт 29 үйлдэгдсэний 29 нь галт тэргэнд,

-Төрийн бус байгууллагад 14 үйлдэгдсэний 10 нь төмөр замын салбар хэсгүүдэд, 4 нь төмөр замын эмнэлэгт

- Төрийн байгууллагад 4 үйлдэгдсэний 2 нь ТЗЦХ-н саатуулах байранд тус тус үйлдэгдсэн байна.

**Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт**

3.1. Гэмт хэргийн илрүүлэлт:

- Гэмт хэргийн илрүүлэлт 75 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,6 хувиар өссөн.

3.2. Илрүүлэлт гэмт хэргийн ангиллаар:




3.3. Бутгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг:




3.4. Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн төрөл

Нийт илрээгүй 9 хэрэг байгаагаас :

- Бусдын эд хөрөнгө хулгайлах-6,

- Бусдын эд хөрөнгө булаах-1 ,

- Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх-1,

- Мөнгө тэмдэгт, үнэт цаас , онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах -1 гэмт хэргүүд байна. Дээрхи хэргүүдээс гадна өмнөх онуудын эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 8 хэрэг түдгэлзүүлээстэй байна.

**Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогчид**

4.1. Гэмт хэрэгт холбогдогчид:

Нийт 104 хүн /өмнөх оны мөн үеэс 10-р өссөн/ гэмт хэрэгт холбогдсоны:

- 31 эмэгтэй буюу 30 хувийг эзэлж байгаа нь урьд оны мөн үеэс 4 буюу 15 хувиар өссөн байна.
- Урьд оны мөн үед 18 хүртэл насны хүүхэд холбогдсон хэрэг 10 гарч байсан бол энэ онд 10 буюу нийт холбогдогчдын 10 хувийг эзэлж байна.

4.2. Гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:




4.3. Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал




**Тав. Гэмт хэргийн хохирогч, хохирол**

5.1. Гэмт хэргийн улмаас:

- 82 иргэн хохирсон, /эмэгтэй-42, хүүхэд-2/
- Нас барсан 3
- Гэмтсэн хүн 29
- Цагдаагийн албан хаагч -7 байна

5.2. Гэмт хэрэгт хохирогчид насны ангиллаар:




5.3. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол



Мөрдөн байцаалтын шатанд нийт хохиролынхоо 71,7 % төлүүлсэн бол  Хэрэг бүртгэлтийн шатанд 91,8 % нөхөн төлүүлж, 62,9 сая төгрөгийн хөрөнгийг мөрдөн байцаалтын шатанд битүүмжилсэн байна. Хэлтсийн нийт хохирол нөхөн төлүүлэлт 73,6 % байна.

5.4 Гэмт хэргийн шийдвэрлэлт

Урьд оны үлдэгдэл 9, тухайн онд шинээр дугаар авсан 103 нийт /урьд оны түдгэлзүүлснээс 6 хэрэг сэргээсэн/ 118 хэрэг шалгаснаас 71 хэрэг хэрэгсэхгүй  болгох саналтай, 25 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт  шилжүүлж, 4 хэргийг түдгэлзүүлж, 5 хэргийг нэгтгэсэн байна. Одоо 13  хэргийн үлдэгдэлтэй байна.

**Зургаа. Захиргааны зөрчил**

6.1. Шалгасан захиргааны зөрчил:

- нийт 19075 захиргааны зөрчил бүртгэгдсэн,
- өмнөх оны мөн үеэс 9482 нэгжээр буюу 98,8 хувиар өссөн /өмнөх онд  бэлэн бусаар торгосон торгууль ордоггүй байсан/
- 18679 иргэнийг 185 сая 522,3 мянган төгрөгөөр торгосон. Үүний 8450 зөрчилд 42 сая 250 мянган төгрөгийг торгуулийн тасалбараар, 10229 зөрчилд 143 сая 272,3 мянган төгрөгийн бэлэн бусаар торгожээ.
- Шийтгэврээр 349 хүнийг 6 сая 739 мянган  төгрөгөөр торгосон байна.
- 39 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж,
- 8 хүнд баривчлах шийтгэл оногдуулсан,
- Торгуулийн хуудсаар 232 гадаадын иргэнийг 1 сая 160 мянган төгрөгөөр торгож, шийтгэврээр 4 гадаадын иргэнд 120,000 төгрөгөөр торгох захиргааны арга хэмжээ авч, 1 гадаад иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

6.2. Захиргааны зөрчлийг шийдвэрлэсэн албан тушаалтан:

- шүүгч 9,
- цагдаагийн алба хаагч 387 захиргааны зөрчил шийдвэрлэсэн байна.

6.3. Шийтгэврээр захиргааны шийтгэл ногдуулсан хууль тогтоомж:

- 321 буюу 81 %-ийг ЗХТХ-аар,
- 55  буюу 14 %-ийг ЗХАБТХ-аар,
- 6 буюу  1,5 %-ийг АСТТХ-аар,
- 14 буюу 3,5 %-ийг ТХТХ-аар тус тус шийтгэл ноогдуулсан байна.

6.4. Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийтгэврээр арга хэмжээ авсан байдал:

-Танхайрах 17,

-ХАБЖ зөрчих 209,

-Галт тэрэгний АБ, ашиглалтын журам зөрчих 60,

-ЦАХ-н хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх 26,

-Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах 7,

-Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэх, гэмтээх 1

6.5. Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгуулийн хуудсаар арга хэмжээ авсан байдал:




## 6.6. Захиргааны зөрчил үйлдэгдсэн газар, зөрчлийн тоо:




-зам дээр үйлдэгдсэн 260 зөрчлийн 230 нь төмөр замын гарам дээр,

-олон нийтийн газар үйлдэгдсэн 38 зөрчлийн 36 нь төмөр замын вокзалд,

-нийтийн тээвэрт 18 үйлдэгдсэний 18 нь галт тэргэнд тус тус үйлдэгдсэн байна.

## 6.7. Бүртгэгдсэн захиргааны зөрчлийн үйлдэгдсэн өдөр:

- 52 нь Даваа гаригт
- 44 нь Мягмар гаригт
- 47 нь Лхагва гаригт
- 57 нь Пүрэв гаригт
- 68 нь Баасан гаригт
- 40 нь Бямба гаригт
- 59 нь Ням гаригт үйлдэгдсэн байна.

## 6.8. Бүртгэгдсэн захиргааны зөрчлийн үйлдэгдсэн цаг:

- 06-12 цагт 123,
- 13-18 цагт 154,
- 19-24 цагт 89
- 01-05 цагт 30 зөрчил тус тус үйлдэгдсэн байна.

## 6.9. Бүртгэгдсэн захиргааны зөрчил үйлдэгдсдийн онцлог:

- 77 нь согтуугаар
- 58 нь эмэгтэй хүн оролцсон
- 33 нь бүлэглэн үйлдсэн
- 5 нь гадаадын иргэн

<u>6.10. Эрүүлжүүлэх үйл ажиллагаа</u>

- 2722 хүн эрүүлжүүлж 11 сая 155,2 мянган төгрөгийн үйлчилгээний хөлс авсан байна.
- 13 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан.

## Долоо: Санхүү, нийгмийн асуудлын талаар хэрэгжүүлсэн ажил

2015 оны IY улиралд улсын төсвөөс ñàíõ¿¿æèëò 1.240.218,5 òºãðºã, үндсэн үйл ажиллагааны орлого буюу цагдаагийн алба хаагч гэрээгээр ажиллуулах гэрээний орлого, бусад орлого 1.291.883,4 төгрөг нийт 2.531.950,1 төгрөгийг төвлөрүүлэн 2.518.448,8 òºãðºãèéã ¿éë àæèëëàãààíû çàðäàëä çàðöóóëñàí. ¯¿íä:

Цалин хөлс нэмэгдэл урамшилд: Үндсэн цалин, нэмэгдэл цалинд 1.318.093,5 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх ÝÌД, ÍÄØ-ä 26.596,9 òºãðºã.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: ãýðýë öàõèëãààíû çàðäàëä 8.819,9 òºãðºã, õàëààëòûí çàðäàëä 15.944.2 òºãðºã, öýâýð áîõèð óñíû çàðäàëä 6.309,3 òºãðºã, áàéðíû ò¿ðýýñ 26.596,2 òºãðºã.

Хангамж бараа материалын зардал: áè÷èã õýðãèéí çàðäàëä 1.276,5 òºãðºã, øóóäàí õîëáîîíû çàðäàëä 2.797,2 òºãðºã, ном, хэвлэлийн зардалд 135,2 төгрөг, Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 521,0 төгрөг.

Нормативт зардал: Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 698,8 төгрөг, Хоол, хүнсэнд 10.000,8 төгрөг,

Эд хогшил, урсгал засварын зардалд: Хөдөлмөр хамгааллын хэрэглэлд 299,4 төгрөг,

Дотоод албан томилолтын зардалд: äîòîîä òîìèëîëòûí çàðäàëä 3.628,5

Бусад урсгал шилжүүлэг: Нýã óäààãèéí òýòãýìæ, шагнал óðàìøóóëàëä1.165,1 òºãðºã,

Бараа, үйлчилгээний бусад зардал: Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 635,0 төгрөг

Харуул хамгаалалтын зардал: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсөнд 1.087.913,0 төгрөг тус тус зарцуулсан

### Санхүүгийн 2013, 2014, 2015 оны 4-р улирлын харьцуулалт:

**Орлого:**

| *Үзүүлэлт* | *2013 он* | *2014 он* | *2015 он* |
|---|---|---|---|
| *Төсвийн санхүүжилт* | 812364100,00 | 726742700,00 | 1004275100,00 |

| | | | |
|---|---|---|---|
| *Системийн дотоод тооцоо* | 2094200,00 | 66858642,00 | 15187028,00 |
| *Үнэ төлбөргүй авсан орлого* | 4049140,00 | 2333178,00 | 67958,00 |
| *Туслах үйл ажиллагааны орлого* | 762146189,00 | 4583567,00 | 0,00 |
| *Үндсэн үйл ажиллагааны орлого* | 0,00 | 767338812,00 | 932946190,25 |

**Орлого/графикаар/**




**Зардал:**

| *Үзүүлэлт* | *2013 он 4-р улирал* | *2014 он 4-р улирал* | *2015 он 4-р улирал* |
|---|---|---|---|
| *Цалин хөлс, нэмэгдэл, НДШ,* | 1221090815,00 | 1366446635,00 | 1675717407,00 |

| | | | |
|---|---|---|---|
| *ЭМД /Үр дүнгийн тайлан/* | | | |
| *Урсгал зардал:* | 138254781,03 | 129846911,37 | 234093274,38 |
| *Бусад зардал* | 30964388,00 | 29419200,00 | 930100,00 |

**Зардал/графикаар/**




**Хөрөнгө:**

| *Үзүүлэлт* | *2013 оны 4-р улирал* | *2014 оны 4-р улирал* | *2015 оны 4-р улирал* |
|---|---|---|---|
| *Бараа материал* | 133541161,41 | 137540681,56 | 134174313,75 |
| *Үндсэн хөрөнгө* | 210833223,27 | 185545168,75 | 165079128,16 |
| *Нийт хөрөнгө - /өглөг авлагаас бусад/* | 569346616,88 | 380700408,31 | 497912576,85 |

**Хөрөнгө /графикаар/**




**Гэрээт харуул хамгаалалтын зардал:**

2015 оны 2-дугаар сарын 17-ны өдөр УБТЗ нийгэмлэгтэй байгуулсан гэрээний төсвөөр 95 офицер, цагдаа ажиллуулахаар 1.229.469,4 төгрөгийн гэрээг хийсэн. 2015 оны 09 сарын 30-ны байдлаар 922.102,0 төгрөгийн санхүүжилт авахаас 922.102.0 төгрөгийн санхүүжилт авсан.

Цалингийн зардалд /ЭМД, ХХОАТ/-645.824,9 төгрөг

Маршрутын томилолтонд 86.280,0 төгрөг

Мөнгөн урамшуулалд 32.809,6 төгрөг

Хоолны зардалд 1.770,2 төгрөг

Цагдаагийн шинэ загварын хувцасны зардалд УБТЗ-аас 2015 онд төсөв хөрөнгө батлаагүй ба 90 алба хаагчдад 9 нэр төрлийн 29.890,7 төгрөгийн хувцас, чимэг хэрэгсэл авсан.

**Урсгал засвар, хангалт үйлчилгээ:**

Албаны байр эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулж саатуулах байр, конторын барилгад 1.856,5 төгрөгийн урсгал засварын материал авсан.

Хүнсний хангалтыг 1-12 сард шөнийн ээлжинд ажилласан 3960 /давхардсан тоо/ алба хаагчид 13.035,0 төгрөгийн хоолны зардал олгосон.

Саатуулах байрны 4 эмчид 232,0 төгрөгийн /даралтын аппарат/, 290,0 төгрөгийн /жин өндөр хэмжигч/ зэрэг эмнэлгийн хэрэгсэл авсан.

Эдийн хангалтаар 8 үйлчлэгч, аж ахуйн материалд 1.010,2 төгрөгөөр хөдөлмөр хамгааллын материал авч хангасан.

Бичиг хэргийн материал, принтерийн хор, принтерийн хор цэнэглэх, бичгийн цаас авахад нийт 2.369,9 төгрөг зарцуулан хангалт хийсэн.

ЦЕГ-ын Санхүү Хангамжийн Газрын хэвлэх хэсгээс 29 нэр төрлийн 1.285,8 төгрөгийн хэвлэмэл материал захиалан хэвлүүлж мөрдөн байцаах, хэрэг бүртгэх, албан бичиг хэрэг хөтлөлтөнд ашиглаж байна.

Алба хаагчдын ажлын байрны нөхцөл, тав тухыг хангах зорилгоор, хөдөлмөр хамгаалалд зориулж 3.168,8 төгрөгийн хөрөнгө зарцуулсан.

Уламжлалт цагаан сарын баяр, Ахмадын баяраар тус хэлтэст ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан давхардсан тоогоор 99 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэхэд 1.770,0 төгрөг зарцуулсан.

Ахмад настан Л.Бадамраа, Ж.Бямбасүрэн нарын ар гэрт буцалтгүй тусламжаар нийт 200,0 төгрөг, Ахмад настан Д.Цэцгээд 100,0 нийт 300,0 төгрөг зарцуулсан.

**Торгууль, шийтгэвэр:**

2015 оны жилийн эхэнд 5000 төгрөгний 88 төгрөгний үнэтэй 1206 ширхэг торгуулийн хуудас, 110 төгрөгний үнэтэй 211 ш шийтгэвэрийн үлдэгдэлтэй байсанаас 1-12 сард Торгуулийн тасалбар 9000 ширхэг орлого авч, 6099 ширхэг торгуулийн хуудсаар 41.145,0 төгрөгийн орлого 347 ширхэг шийтгэвэр зарлага болгож 6.375,7 төгрөгийн орлого нийт 47.520,7

төгрөгийн орлогыг ЦЕГ-ын торгууль шийтгэврийн дансанд төвлөрүүлж ажиллаа.

Цаашид хийх ажил: Цагдаагийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх тухай Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 03 дугаар албан даалгавар, санхүүгийн албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажиллах.

Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдэээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам, мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмын дагуу байгууллагын төсөв, өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавихад “Шилэн дансны хуулийн”-ийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг хугацаанд нь хүргүүлж хэвших,

Төсөв, санхүүгийн хүндрэлтэй холбоотойгоор урсгал зардлаас тэвчиж болох зардлыг хассантай холбоотой, хэмнэлтийн горимд шилжих.

**Найм: Бусад ажлын талаар:**

Төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүãèéí, эдийн засгийн áîëîí хэсгийн төлөөлөгч нар 2015 онд нийт 230 мэдээ, мэдээлэл олж шалган 65 холбогдогчтой 2 тэрбум 654 сая төгрөгний хохиролтой 78 гэмт хэрэг, үйлдэл илрүүлсэн.

Гэмт хэрэгтэй тэмцэх тасаг нь эрэн сурвалжлах ажлыг зохион явуулахдаа Монгол улсын Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, “Гүйцэтгэх ажлын заавар”, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 420 тоот тушаалаар батлагдсан “Эрэн сурвалжлах ажлын журам”, 2011 оны А/01 тоот албан даалгавар, Цагдаагийн Ерөнхий Газрын тэргүүн дэд даргын 2011 оны 2/312 тоот үүрэг, Эрүүгийн цагдаагийн газрын даргын 2012 оны 01 тоот албан даалгавар, Эрүүгийн цагдаагийн газрын даргын 2013.12.04-ний өдрийн 9/755 дугаартай үүрэг хүргүүлэх тухай албан даалгавар болон бусад эрх зүйн актуудыг үндэслэл болгон үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах ажлын “ASAP” санд  тус хэлтсээс оргодол 3, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 6, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 4, гэрээсээ гараад сураггүй алга болсон 1, эд зүйл 1, аман зургаар 1 нийт 16 эрэн сурвалжлах хүн, цогцос, эд зүйлсийн мэдээлэл бүртгэгдэж зарлагдсан ба үүнээс оргодол 3, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 5, хэн тогтоогдоогүй цогцос 4, гэрээсээ гараад сураггүй алга блосон 1, эд зүйл 1, аман зургаар 1  нийт 15 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

Үүнд:

1. Тус хэлтсээс эрүүгийн 201424001258 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000002 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 21 настай Нямдорж овогтой Банзрагч РД:/ИГ94040830/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,
2. Тус хэлтсээс эрүүгийн 201424001112 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000001 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 50 настай Шагдар овогтой Жаргалсайхан РД:/ТА65051731/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

3. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000009 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 21 настай Батболд овогтой Баасанжаргал РД:/МИ96032206/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

4. Тус хэлтсээс эрүүгийн 20152400008 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000005 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 25 настай Очирдагва овогтой Бямба-Очир РД:/ЖЮ97120611/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

5. Тус хэлтсээс эрүүгийн 201424001112 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000006 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 49 настай Оргил овогтой Баттөмөр РД:/ТД66112111/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

6. Тус хэлтсээс эрүүгийн 201524000266 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000011 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 38 настай Сүхээ овогтой Батхүү РД:/ТД77051377/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

7. Тус хэлтсээс эрүүгийн 201524000017 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000004 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 29 настай Ичинхорлоо овогтой Сайханбаатар РД:/ФБ86050675/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг

8. Тус хэлтсээс эрүүгийн 201524000157 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000007 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 46 настай Жадваа овогтой Батмөнх РД:/ЧЙ69110778/ болохыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

9. Тус хэлтсээс Эрэн сурьалжлах “ASAP” санд 540001315000015 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 21 настай Гантулгын Бямбаноров /РД:УХ94101550/-ыг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласаныг илтгэн танилцуулъя.

10. Тус хэлтсээс эрүүгийн 201524000563 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000016 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 19 настай Энхболд овогтой Долгормаа РД:/УШ96011201/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

11. Тус хэлтсээс эрүүгийн 201524000731 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000015 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 22 настай Гантулга овогтой Бямбаноров РД:/УХ94101550/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

12. Тус хэлтсээс эрүүгийн 201524000851 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000018 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 19 настай Ануар овогтой Юра РД:/БЮ75122009/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

13. Тус хэлтсээс эрүүгийн 201524000887 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000020 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 19 настай Наранчимэг овогтой Ганбүүвэй РД:/ЕА98062611/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

14. Тус хэлтсээс эрүүгийн 201524000924 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд маягтын 54170131500005 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 34 настай Отгонбаатар овогтой Шатардорж РД:/УЕ81091775/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

15. Тус хэлтсээс эрүүгийн 201524000977 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000024 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан Энхболдын Анхболд /РД:ЕЙ89062814/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг тус тус зогсоосон байна.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн газар хэлтсээс Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах “ASAP сан”-д бүртгэгдэж зарласан оргодол 7, гэрээсээ гараад сураггүй алга

болсон 2, шүүхээс эрэн сурвалжлагдаж байсан 3 нийт 12 олж тогтоон нутаг дэвсгэрийн цагдаагийн хэлтсүүдэд хүлээлгэн өгч ажилласан байна.Үүнд:

1. СБД-ийн Цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн 2014250004069 тоот дугаартай хэрэгт "Эрэн сурвалжлах АСАП" санд 540005814000580 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 44 настай Лхашидын Баянхүүг РД:/ХИ71012717/ олж тогтоон СБД-ийн Цагдаагийн 2-р хэлтэст,
2. СХД-ийн Цагдаагийн 2-р хэлтсээс "Эрэн сурвалжлах АСАП" санд 540005615000036 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 16 нсатай Дулам овогтой Уранхай РД:/УП98051006/-г олж тогтоон СХД-ийн Цагдаагийн 2-р хэлтэст,
3. СХД-ийн Цагдаагийн 3-р хэлтсээс эрүүгийн 2015260000282 тоот хэрэгт "Эрэн сурвалжлах АСАП" санд 54000631000054 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 16 нсатай Дулам овогтой Уранхай РД:/УП98051006/-г олж тогтоон СХД-ийн Цагдаагийн 2-р хэлтэст,
4. БГД-ийн Цагдаагийн 1-р хэлтсээс эрүүгийн 2015260000261 тоот хэрэгт "Эрэн сурвалжлах АСАП" санд 540005115000055 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 29 настай Ганбаатар овогтой Ариунцэцэг РД:/ТЖ86120305/-ыг олж тогтоон БГД-ийн Цагдаагийн 1-р хэлтэст,
5. СБД-ийн Цагдаагийн 1-р хэлтсээс "Эрэн сурвалжлах АСАП" санд 540005715000274 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 30 настай Хасгаа овогтой Солонго РД:/ЦА85010567/-ыг олж тогтоон СБД-ийн Цагдаагийн 2-р хэлтэст,
6. БГД-ийн Цагдаагийн 1-р хэлтсээс эрүүгийн 2014260004197 тоот хэрэгт "Эрэн сурвалжлах АСАП" санд 540005114000613 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 45 настай Молотов овогтой Жаргалсайхан РД:/ХЗ70091211/-ныг олж тогтоон БГД-ийн Цагдаагийн 1-р хэлтэст,
7. СХД-ийн Цагдаагийн 1-р хэлтсээс эрүүгийн 2014260006278 тоот хэрэгт "Эрэн сурвалжлах АСАП" санд 540005515000145 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 26 настай Гансүх овогтой Амарсанаа РД:/УХ89021996/-ыг олж тогтоон СХД-ийн Цагдаагийн 1-р хэлтэст,
8. СХД-ийн Цагдаагийн 3-р хэлтсээс эрүүгийн тоот хэрэгт "Эрэн сурвалжлах АСАП" санд 540006315000372 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 27 настай Пүрэвдорж овогтой Өлзийбаяр РД:/УП88100785/-ыг олж тогтоон СХД-ийн Цагдаагийн 3-р хэлтэст,
9. СХД-ийн Цагдаагийн 2-р хэлтсээс "Эрэн сурвалжлах АСАП" санд 540005615000217 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 42 настай Сүхбаатар овогтой Уранчимэг РД:/ЧЕ73071563/-ыг олж тогтоон СХД-ийн Цагдаагийн 2-р хэлтэст,
10. ЧД-ийн Цагдаагийн 2-р хэлтсээс эрүүгийн 201301051428 тоот дугаартай хэрэгт "Эрэн сурвалжлах АСАП" санд 540006214000039 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан Нэргүй овогтой Туул /РД:НВ77060915/ олж тогтоон ЧД-ийн Цагдаагийн 2-р хэлтэст,
11. ХУД-ийн Цагдаагийн 1-р хэлтсээс "Эрэн сурвалжлах АСАП" санд 540105915000120 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 33 настай Бэхбат овогтой Уранчимэг РД:/ШВ82051306/-ыг олж тогтоон ХУД-ийн Цагдаагийн 1-р хэлтэст хүлээлгэн өгч эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласаныг илтгэн танилцуулъя

12. ЧД-ийн цагдаагийн 1-р хэлтээс “Эрэн сурвалжлах ASAP” санд 540002512000511 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 32 настай Дашням овогтой Наранcайхан РД:/ЧР83060306/-ыг олж тогтоон ЧД-ийн Цагдаагийн 1-р хэлтэст хүлээлгэн өгч эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан байна.

**Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн сэтгэл зүйчийн зүгээс:**

- Хэлтсийн дарга болон тасгийн дарга нарын удирдлагын арга барилыг тодорхойлох, анхаарах суудлын талаарх санал асуулгын дүнгийн талаарх илтгэх хуудсыг удирдах ажилтан тус бүрээр гарган сэтгэл зүйн зөвлөмжийн хамт өгөв.
- 3 тасгийн дарга, 3 салаан дарга, хэв журам хариуцсан ахлах байцаагч, саатуулах байрны дарга нарт алба хаагчдын бие хүний хувийн онцлогийг харгалзан хэрхэн харилцах талаарх зөвлөмжийг хагас жил тутамд 2 удаа өгөв.
- Тус хэлтсийн 2014 оны “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний тайланг гарган, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналын хамт хэлтсийн удирдлагад болон алба хаагчдад танилцуулав.
- Ажлын нөхцөл байдал, амьдрал ахуйн талаарх сэтгэл зүйн тандалт ярилцлагыг давхардсан тоогоор 366 алба хаагчтай хийв.
- Дасан зохицох хөтөлбөрийн хүрээнд тус хэлтэст шилжиж ирсэн болон шинээр томилогдсон, офицер албан тушаалд томилогдсон давхардсан тоогоор 22 алба хаагчтай ярилцлага хийж, санал сэтгэгдлийг сонсож, дасан зохицох сэтгэл зүйн бэлтгэлийг хангуулж ажиллав.
- Сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргасан 10 алба хаагчтай шалтгаан нөхцлийг тогтоох, сэтгэл зүйн хямрал, гутрал байсан эсэх талаар болон тайвшруулах ярилцлага хийн, дүгнэлтийг, 2 алба хаагчийн сэтгэл зүйн тодорхойлолтын хамт холбогдох ажилтанд өгөв.
- Тус хэлтэст шилжин ирэх хүсэлт гаргасан 6, цагдаагийн байгууллагад анх удаа орохоор хүсэлт гаргасан 6, нийт 12 иргэнтэй сэтгэл зүйн онцлог тодорхойлох ярилцлага хийн, бие хүний сэтгэл зүйн чанар, сэтгэл хөдлөл мэдрэмж, ёс зүйн харилцаа, оюун ухааны чадварын төвшинг тодорхойлох сорил авч дүгнэн, сэтгэл зүйн тодорхойлолтыг холбогдох ажилтанд өгч ажиллав.
- Хэлтсийн бие бүрэлдэхүүний темпераментын онцлогийг зан төлвийн хурцдалтай нийцүүлсэн байдлын нэгдсэн судалгааг гарган удирдлагад танилцуулж, алба хаагч бүрийн сэтгэл зүйн хувийн хэргийн баяжилтыг хийв.
- Тус хэлтсээс 2015 онд алба хаагчдын нийгмийн асуудлын болон сэтгэл зүйн аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажлын тайлан, орон сууцны зээлтэй алба хаагчдын, цалингийн зээлтэй алба хаагчдын өрх тэргүүлсэн алба хаагчдын, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлогтой алба хаагчдын, сэтгэл ханамжийн байдлын судалгаануудыг гарган удирдлагыг мэдээллээр ханган танилцуулав.
- Тус хэлтсийн 1-р салааны 29 алба хаагч, 2-р салааны 10 алба хаагч, 3-р салааны 25 алба хаагч, нийт 64 алба хаагчийн ар гэрээр орж амьдралын түүхийн судалгаа хийв.
- ЦЕГ-ын ХНСХ-ийн мэдэлд “Төрийн тусгай албаны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд орж ажиллан 753 иргэнээс сэтгэл зүйн сорил авах, цагдаагийн байгууллагад эргэн орох хүсэлт гарсан 153 иргэнтэй ярилцлага хийсний 43 иргэний дүгнэлтийг гаргав.

- “Цагдаагийн алба хаагчийн сахилга ёс зүй, харилцааны ур чадварыг дээшлүүлэх” сургагч багшийн вакумжуулсан 3 хоногийн сургалт болон сургагч багшийг чадавхжуулах 3 өдрийн, ХСИС байгууллагуудын сэтгэл зүйчдийн 2 өдрийн, Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх 5 өдрийн сургалтанд тус тус хамрагдав.
- Сэтгэл зүйчийн багц сургалтын хүрээнд “Ажлын байрны стресс”, “Зөв харилцаанд суралцах нь”, “Өөртөө илтгэх итгэл амжилтын үндэс”, “Бие хүний онцлогийг харгалзан харилцах нь”, Уурын менежмент”, “Цагийн менежмент”, “Жендэр болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бие махбодь, сэтгэл зүйн ялгаа”, “Жендэрийн тэгш байдлыг хангах “тухай хуулийн хялбаршуулсан сургалт
- Гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн алба хаагчдад “Гэрч, хохирогч, сэжигтэнтэй харилцах ажиллагаа, анхаарах асуудал” сэдвээр 2 цагийн сургалт оров.
- ХСИС-ийн Цагдаагийн сургуулийг төгсөх ангийн сонсогчдоос авах ажлын хэсэгт орж ажиллан 201 сонсогчоос сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох 5 төрлийн тест авч, 9 сонсогчийн сэтгэл зүйн дүгнэлтийг хугацаанд нь чанартай хийж өгөв.
- ЦЕГ-ын ДХАБГ-аас ирүүлсэн алба бичгийн дагуу 3 удаа 5 өдөр ажиллаж нийт 4 байгууллагын 2039 санал асуулгын хуудас түүвэрлэн, дүгнэлтийг гарган өгч ажилласан.
- “Тоглоом” цуглуулах хандивын үйл ажиллагаа зохион байгуулж, 84 алба хаагч хамрагдан, УБХЦГ-ын ГБХТХ-ийн хамгаалах байранд хүлээлгэн өгөв.
- Засгийн газрын 34, 37-р тогтоол, ЦЕГ-ын 05 тоот албан даалгаврын 2015 оны эхний хагас жилийн биелэлтүүдийг, “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн биелэлт болон Жендэрийн тэгш байдлыг хангах ЦЕГ-ын дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний биелэлтийг хагас, бүтэн жилээр тус тус гарган хугацаанд нь хариуг явуулав.
- Сэтгэл ханамжийн судалгааг 100 алба хаагчаас авч боловсруулалтыг хийв.
- ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын баталсан удирдамжийн дагуу Сургалтын төвөөс зохион байгуулж буй “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага” сэдэвт модуль сургалтанд 8 өдөр сургагч багшаар томилогдон ЦЕГ-ын харъяа газар хэлтсүүдийн 97 алба хаагчдад 64 цагийн сургалт орж ажиллав.
- Тус хэлтэст ашиглагдаж байсан хөдөлмөр хамгааллын сандлыг актлан устгалд оруулж, шинээр 3 компаний үнийн санал, судалгааг гарган, Монос фарм ХХК-ны хөдөлмөр хамгааллын сандлаар хангагдан 92 алба хаагчид үйлчилгээ үзүүлэв.
- Хэлтсийн ахлагч бүрэлдэхүүний ар гэрийнхэний санал хүсэлтийг сонсох, хэлтсийн удирдлага-алба хаагч-ар гэрийн эргэх холбоог сайжруулах зорилгоор “Тэнгэрлэг” гэр бүл” ар гэрийн уулзалтыг зохион байгуулав.

**Нийтийн хэв журам хамгаалах тасгийн**
**Жижүүрийн шуурхай удирдлагын хэсгээс:**

ЦБҮАЖ-ны код 200.4.4. 202-т заасны дагуу албан байгууллага, иргэдээс 518 мэдээ мэдээлэл, дуудлага хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 111, захиргааны зөрчлийн шинжтэй 400, дуудлага буцаагдсан 4, газар дээр нь зохицуулсан 3 мэдээлэл хүлээн авсан. ЦБҮАЖ-ын код 201.5.6 заасны дагуу төвөөс сүлжээгээр гэмт хэргийн-3012, хүн

болон эд зүйл эрэн сурвалжилсан-2987 зарлан мэдээлэл хүлээн авч, эргүүл постонд дамжуулан эрэн сурвалжлах ажиллагаа зохион байгуулж ажилласан.

ОХУ-н төрийн ДУМ-н дарга, Е.С Нарышкин Монгол улсад айлчилсан, Унгар улсын Ерөнхийлөгч Янош Адер, гэргийн Хээнцэр Анита нарын зочид төлөөлөгчид Монгол улсад айлчилсан, Бүгд Найрамдах Болгар улсын Ерөнхийлөгч Росен Плевнелив тэргүүтэй зочид төлөөлөгчид Монгол улсад айлчилсан,Бүгд Найрамдах Энэтхэг улсын Ерөнхий сайд Наренда Моди тэргүүтэй зочид төлөөлөгчид Монгол улсад айлчилсан, Холбооны бүгд Найрамдах Мьянмар улсын Ерөнхийлөгч Тейн Сейн тэргүүтэй зочид төлөөлөгчид Монгол улсад айлчилсан, БН Чех улсын парламентын танхимын дарга, БНСУ-н Ерөнхийлөгч асан тэргүүтэй зочид төлөөлөгчид Монгол улсад айлчилсан, Холбооны бүгд найрамдах Герман улсын Ерөнхийлөгч Гаукын Монгол улсын хийсэн төрийн айлчлал хийх үеийн болон Төмөр замын үйлдвэрчний эвлэлийн 60-н жилийн ойн баяр, Төмөр замын баярын хамгаалалт, Үндэсний их баяр наадам, Даншиг наадам, Европын аюулгүй байдал Парламентын Ассамблейн намрын ээлжит чуулганы зочид төлөөлөгчид Монгол улсад ирэх явах үеийн, Япон улсын Ерөнхий сайд эрхэмсэг ноён Шинзо Абэ Монгол улсад хийсэн албан ёсны айлчлал, БНХАУ-н бүх Хятадын ардын төлөөлөгчдийн их хурлын байнгын хорооны дэд дарга Янь Зюньчи МУ-д айлчилсан, БНСУ-ын Ерөнхий сайд эрхэмсэг ноён Хван Гё Ан МУ-д хийсэн албан ёсны айлчлал зэрэг нийт 1 дүгээр зэрэглэлийн 11 хамгаалалт, бусад 22 хамгаалалтанд батлагдсан төлөвлөгөө хуваарийн дагуу аюулгүй байдлыг хангаж, нөхцөл байдлын талаар ЦЕГ-ын ШУШтабд болон шонхортой тухай бүр холбогдож ажилласан ба хамгаалалтын үеэр алба хаагчдаас ямар нэг зөрчил дутагдалгүй хэвийн ажилласан..

Суудлын галт тэрэг болон шугам зам өртөөнүүдэд давхардсан тоогоор 8 офицер, 138 цагдаа эргүүлийн үүрэг гүйцэтгэж 9008 зөрчил илрүүлэн 45.040.000 төгрөгний торгууль ноогдуулж, шүүхээр 8 хүнийг 7-30 хоног баривчлуулсныг бүртгэн хоногийн мэдээнд тусгасан.

Саатуулах байр нь 2015 онд архидан согтуурч, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 2892 эмэгтэйг хүлээн авч саатуулсанаас 2834 хүнээс 11873550 төгрөгний төлбөр гаргуулахад хяналт тавьж хэлтсийн хоногийн мэдээнд тусган ажилласан. УБТЗ-н ГУА-ийн жижүүйн утас 244078, Хөдөлгөөн зохицуулах жижүүрийн 244119, 244610 дугаарын утастай тогтмол холбоотой ажиллаж мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

**Хүүхдийн албанаас:**

Монгол улсын засгийн газрын 58-р тогтоол “ Олон нийт цагдаа хамтын ажиллагаа”-ны хүрээнд төмөр замын хүүхдийн байгууллагатай хамтран байгуулсан түншлэлийн гэрээний дагуу 2015.08.25-нд хүүхдийн байгууллагын төвд байрлах 5 цэцэрлэгт олон нийтийн эргүүл хийж хүүхдийн байгууллагын хүний нөөцийн менежир Мөнхцэцэг, байцаагч Баяраа нар хамрагдаж 3 цэцэрлэгээс 5 зөрчил илрүүлж зөрчлийг арилгуулсан. Хүүхдийн байгууллагын харъяа цэцэрлэгүүдэд гэмт хэрэг, зөрчил ихсэж байгаа тул 2010 оноос хойш цэцэрлэгүүд дээр гарсан мэт хэргийн судалгааг сүүлийн 4 жилээр гаргаж, камерийн хяналтыг сайжруулах тал дээр төвийн цэцэрлэгүүдийн эрхлэгч, хүүхдийн байгууллагын дарга нартай уулзаж камерын хяналтыг зөв зохистой газар байрлуулах, шинээр камер тавьж байгаа цэцэрлэгүүдэд зөвлөгөө өгсөн. Одоогийн

байдлаар ХБХ 3, 1 дүгээр цэцэрлэгийн камерыг шинэчилж, камерын хяналт байх шаардлагатай газруудад нэмж камер тавих санал өгсөн.

Хүүхдийн байгууллагын харъяа хандгайт зусланд амарч байгаа хүүхдүүдэд 2015.08.10 , 2015.08.18нд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 30 минутын яриа хийж, тэнд ажиллах багш нарт зүй зохистой байх, архи, тамхи хэрэглэхгүй, зөрчил гаргахгүй байх талаар сануулж ажилласан.

Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудалдхэв журмын байцаагчаар 15 удаа үүрэг гүйцэтгэж суудалд үүрэг гүйцэтгэхээр явж байгаа цагдаа нарын ажлын бэлтгэл, цаг ашиглалтанд хяналт тавьж, вокзалын ойр орчимд эргүүл шалгалт хийж ажилласан.

2015 оны 08 дугаар сарын 23-ны 18цагт төмөр замын 349-р км 10-р зуутад төмөр зам дээр чулуу тавьсан байсныг ачааны 251-р галт тэрэг дайрч явсан гэх материалыг шалгахад С.Ууганжаргал, Б.Чонохүү, Б.Сүхбат, Т.Мягмарнаран, С.Бат-амгалан, нарыг бүртгэл судалгаанд авч, эцэг эх ар гэрийхэнтэй уулзаж яриа таниулага хийсэн. Чулуу тавьсан гэх С.Ууганжаргал нар нь насанд хүрээгүй байх нь гэмт хэргийн бүрэлдхүүнгүй байх тул Монгол Улсын ЭБШ хуулийн 175 дугаар зүйлийн удирдлага болон эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал прокурорт хүргүүлсэн.

Монгол улсын засгийн газрын 58 дугаар тогтоол “Олон нийт-цагдаа” хамтын ажиллагаа хөтөлбөр, Улаанбаатар төмөр замын хэмжээнд гэмт хэрэг, авилгалаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлын хүрээнд ЦЕГ-ын харьяа Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс, УБТЗ-ын Удирдах газартай хамтарсан Түншлэлийн гэрээний дагуу гэмт хэрэг зөрчилөөс урьдчилан сэргийлэх, МУ-ын архидан согтуурахтай тэмуэх тухай хуулийн хэрэгжилтийн хангах ажлын хүрээнд Улаанбаатар төмөр замын харьяа архи, согтууруулах ундаа зарж борлуулдаг болон түүгээр үйлчилдэг аж ахуй нэгж албан байгууллагуудын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилт, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж байгаа ажил үйлчилгээ болон зөрчил дутагдалыг илрүүлэн шалгах зорилгоор **“Хяналт, шалгалт”** арга хэмжээг саатуулах байрны дарга, цагдаагийн ахмад Ө.Баярмаа, ахлах байцаагч цагдаагийн ахмад Д.Өнөртөгс нар зохион байгуулсан.

Шалгалтаар Улаанбаатар төмөр замын архи худалдан борлуулдаг 3 аж ахуй нэгжийг шалгах, ХБХ сурагчдын дотуур байрны 9-11 дүгээр ангийн 42 хүүхдэд Архи мансууруулах бодисын хор холбогдол, гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, цаашид гарах үр дагавар сэдвээр сургалт зохион байгуулан ажилсан. Хичээлийн жил эхэлсэнтэй холбогдуулан УБТЗ-н мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг продник, үйлчилгээний ангид суралцдаг 32 хүүхдэд гэр бүлийн хүчирхийлэл, гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, тамхины хяналтын хууль архидан согтууруулахтай тэмцэх тухай хууль, хүүхдийг эрхийг хамгаалах тухай хуулиудыг суртаялан таниулж сургалт зохион байгуулан ажилласан.

2015.09.17-ны өдөр хүүхдийн байгууллагын 4-р цэцэрлэг дээр хүүхдийн байгууллагын төвийн бүсийн цэцэрлэгүүдийн харуул, сахиул, слесарь нарын нийт 7 ажилтны эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор цагдаагийн албаны тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэл, тамхины хяналтын хууль, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, хүүхдийн эрхийг хамгаалах хуулиудыг таниулан сурталчилсан, мөн архины хор холбогдлын талаар тус хэлтсээс гаргасан “Хожимдсон гэмшил” нэвтрүүлэг үзүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр насанд хүрээгүй хүүхдүүдтэй хэрхэн харьцах талаар зөвлөмж өгсөн.

УБЗҮТБ-н танхимд “Нээлттэй өдөр” зохион байгуулж 12 төрлийн 1200 ширхэг гарын авлага материал тарааж 35 иргэнд эрх зүйн зөвөлгөө өгч, 45 иргэнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, 70 иргэнээс санал асуулга авсан. Замын-Үүдийн ачаа тээвэр, зорчигч үйлчилгээний ангид “Нээлттэй өдөр 2”-г зохион байгуулж “Бидний орчин

хүчирхийлэлгүй орчин” аяны хүрээнд хүчирхийллийн эсрэг яриа таниулга хийж, арга хэмжээнд 65 ажилтан хамрагдаж 760 иргэнээс санал асуулга авсан.

Хүүхдийн байгууллагын 5-н цэцэрлэг, УБТЗ-н төв засварын газарт хэлтсийн 2014 оны үйл ажиллагааны тайланг тавьсан.

УБЗҮТБ орчмоор дэмий сэлгүүцэн явсан Я.Батзориг /12 нас/, М.Энхтүвшин /12 нас/, Г.Бөхбат /12 нас/, Г.Энх-Амгалан /12 нас/, Т.Билгүүн /10 нас/, С.Дөлгөөн /12 нас/, Л.Энхтөр /14 нас/, М.Энхжаргал /11 нас/, Э.Түвшинбилэг /14 нас/, нарын 9-н хүүхдийг бүртгэл судалгаанд авч, 8-н хүүхдийг ар гэрт нь, Т.Билгүүнийг хүчирхийллийн эсрэг хамгаалах байранд хүлээлгэн өгсөн.

“Олон нийт-Цагдаа хамтын ажиллагаа “хөтөлбөрийн хүрээнд “ Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль” “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэд олон нийтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ахиц дэвшил гаргах зорилгоор УБТЗ-н ЗҮТБ, ерөнхий боловсролын сургуулиуд, УБ цагдаагийн хүрээний газар хэлтсүүд, авто радио, fm-96,3, УБТЗ-н байгууллага аж ахуйн нэгжүүдийг хамруулан 2015.03.18-с 2015.06.01-ний хоорond “Бидний орчин хүчирхийлэлгүй орчин” арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулсан. Арга хэмжээнд санаачлагч байгууллагаар ЦЕГ, УБТЗ, Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс, Хүүхэд, залуучууд хөгжил дэвшлийн төв, Монголын сурагчдын холбоодыг оролцуулж, хамтрагч байгууллагаар “Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв”, “Итгэл, найдвар, хайр төв”, “Монголын ирээдүй эрүүл хүүхэд төв”, “Цөлийн сарнай” сан зэрэг байгууллагыг оролцуулан ажилласан.

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар:**

Монгол улсын Засгийн газар, Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилт, чиг бодлого, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн байгууллагатай холбоотой хууль тогтоомж тэдгээрийг биелүүлэхэд нийцүүлэн гаргасан журам, заавар, тушаал, шийдвэр,төмөр замын удирдах газрын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Замын даргын 99 тоот албан даалгаврын дагуу Улаанбаатар хот дахь 27 байгууллагыг оролцуулан “Олон нийтийн эргүүл”-ийн хуваарь хийж, Амгалан, Толгойт, төвийн гэсэн 3 чиглэлд 8 удаа 8 офицер, 10 замчин ажиллаж төмөр замын харъяа байгууллагын харуул манааны сонор, сэрэмж, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавин ажилласан. Олон нийтийн эргүүлийн үед зөрчил заагдсан 3 байгууллагын удирдлагад зөрчлийг засуулах талаар албан мэдэгдэл хүргүүлж хариуг хугацаанд нь авч ажиллаа.

Төмөр замын салбарт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хэлтсийн хэмжээнд 88 албан мэдэгдэл бичиж, 75 хариуг авсан.

Монгол улсын засгийн газрын 2007 оны 13 тоот албан даалгавар, цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, байгууллагынхаа үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, төмөр замчдын санал хүсэлтийг сонсож түүнийг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөлт, зохион байгуулалт, Эрүүгийн цагдаагийн тасаг, Хэрэг бүртгэх,

мөрдөн байцаах тасаг, Хэв журмын тасаг гэсэн 4 тасагт нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах хуваарийг гарган хэлтсийн даргаар батлуулж, хуваарийн дагуу "Нээлттэй хаалганы өдөрлөг-1,2,3,4,5,6,7,8,9,10" зэрэг нийт 10 удаа төмөр замын харъяа Суудлын вагон депо, Тээврийн дээд сургууль, Сайншанд зангилаа, Гал унтраах анги, Улаанбаатар зорчигч үйлчилгээни төв буудал, Чойр зангилаа, Амгалан, Төв эмнэлэг, Төв засврын газар зэрэг нийт 10 байгууллагын 1050 иргэн хамрагдсан.

Мөн Суудлын вагон депогийн 12 цуваны галт тэрэгний дарга, үйлчлэгч зэрэг нийт 150, улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудлын резевчин 5, үйлчлүүлэгч 10 , улаанбаатар төмөр замын худалдаа үйлчилгээний төвийн харуул, авто баазын харуулууд, төмөр замын эд хөрөнгийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэ, инженер Болормаа, замын 2 дугаар ангийн ерөнхий инженер Энхтулга, хөдөлгөөн зохицуулалтын албаны байцаагч Лувсан зэрэг 8 хүний бүрэлдэхүүнтэй ажилын хэсэгт толгойт өртөөнөөс амгалан өртөө хүртэлх төмөр замын зурвас дагуу байрласан 75 аж аж хуйн нэгжээр биечлэн орж судалгааг хийн, аж ахуйн нэгж байгууллага болон айл өрхүүдээр орж аюултай бүсийн талаар яриа таниулга хийсэн. 2015 оны 09 дүгээр сард нийт 79 аж ахуйн нэгж байгууллага болон айл өрхийн 3275 иргэнд 25 удаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дайвар ачаа тээш болон архины хор холбогдлын талаар сургалт зохион байгуулж, 50 иргэнд зөвлөгөө өгч, 5 төрлийн 3275 ширхэг санамж материал тараан ажиллаа.

Мөн тус хэлтсийн саатуулах байранд саатуулагдсан насанд хүрээгүй С гэгчтэй уулзаж архины хор холбогдол болон хууль эрх зүйн зөвлөгөө өгч, бүртгэл судалгаанд хамруулсан.

Монгол улсын Засгийн газрын 58 дугаар тогтоол "Олон нийт-цагдаа" хамтын ажиллагаа хөтөлбөр, Улаанбаатар төмөр замын хэмжээнд гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлын хүрээнд төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааг сурталчилж 80х60 хэмжээтэй хулдаасан хэвлэл болон ган зам сонинд өнгөт нүүрэнд хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа М.Отгонбаярын зурагтай мэндчилгээ болон тус хэлтсийн үйл ажиллагааг сурталчилсан. Мөн монголын цагдаагийн баяр болж байгаатай холбогдуулан төв цэнгэлдэх хүрээлэнгийн 1 дүгээр хаалганы орчим хэлтэс сурталчилсан анонос, тусгай хэрэгсэл, тус хэлтсийн түүхийг харуулсан фото альбом зэрэг зүйлийг ширээн дээр байрлуулан сонирхсон 10 игэнд хэлтсийнхээ үүх түүх болон үйл ажиллагааны талаар танилцуулсан. ЦЕГ-ын харьяа Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс, УБТЗ-ын Удирдах газартай хамтарсан Түншлэлийн гэрээний дагуу Гэмт хэрэг зөрчилөөс урьдчилан сэргийлэх, МУ-ын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улаанбаатар төмөр замын харьяа архи, согтууруулах ундаа зарж борлуулдаг болон түүгээр үйлчилдэг аж ахуй нэгж албан байгууллагуудын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилт, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж байгаа ажил үйлчилгээ болон зөрчил дутагдалыг илрүүлэн шалгах зорилгоор "Хяналт, шалгалт" арга хэмжээг

саатуулах байрны дарга, цагдаагийн ахмад Ө.Баярмаа, хүүхдийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Азжаргал нарын хамт зохион байгуулан ажиллаа.

Шалгалтаар Улаанбаатар төмөр замын архи худалдан борлуулдаг 3 аж ахуй нэгжийг шалгаж, гарсан зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна.

2015 онд нээлттэй хаалганы өдөрлөгийг 10 удаа, “ Хяналт шалгалт”, Анхааруулга,” Тэрэгчин”,”Олон нийт-цагдаа хамтын ажиллагааны өдөр” өдөрлөг, техникийн бүрэн бүтэн байдал, Аюултай бүс”, Шалгалт”, урд чиглэл”, Согтуу1, 2,”, Бидний орчин хүчирхийлэлгүй орчин”, “ Сахилга ёс зүйг дээшлүүлье”, “Чулуу”,” Төмөр замын гарам”, “Нүүрс” Вокзал-1,2,3,4, Баримт бичгийн шалгалт”” Мэдээлэл сурталчилгааны галт тэрэг”, “Тэнгэрлэг гэр бүл” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ 30-г зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаа.

Галт тэргээр зорчих иргэдийн тоо ихэсч байгаатай холбогдуулан зорчигчдод хулгайд эд зүйлээ алдах, эд зүйлээ мартаж буухаас болгоомжилж, сонор сэрэмжтэй үйлчлүүлэх талаар, Төмөр зам аюултай бүс, төмөр зам дээр чулуу тавьж байгаа талаар сэрэмжлүүлэгийг, тарваган тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ТҮ5, ТҮ9, С1, NBS, Монгол телевиз, цагдаагийн ерөнхий газрын дуудлага студи зэрэг нийт 6 телевизэд 10 удаа сэрэмжлүүлэг өгсөн.

Мөн төмөр замын бүсэд гарч байгаа гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Маск” продакшины жүжигчин Ц.Ганзориг, А.Жавхлан, Г.Гэрэлцэцэг нараар сэрэмжлүүлэг бэлтгэн MNB,ТҮ5, ТҮ9, С1, NBS,UBS Монгол HD, 25TV Eagle зэрэг 10 телевиз, цагдаагийн ерөнхий газрын дуудлага студи зэрэгт олон нийтэд сурталчлан хамтарч ажиллахыг хүссэн албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ган зам сонин, доргио mn. Shogt mn.зэрэг сайтуудад сэрэмжлүүлэг өгсөн болно.

Төмөр замын харъяа шугам зам дагуух Чойр, Сайншанд, Замын Үүд, Зүүнхараа, Дархан, Сүхбаатар зангилаадын төмөр замчид болон улаанбаатар хот доторхи гал унтраах анги, ус хангамж эрч хүчний 1 дүгээр анги, суудлын вагон депо, тээврийн дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрллийн төв, төв эмнэлэг зэрэг 25 байгууллагын 3275 ажилтан, оюутан сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, 8 төрлийн 4582 ширхэг санамж материал тараан ажиллаа.

Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудлын дарга Батчимэгтэй хамтран холбогдох газарт тамхины цэг байрлуулах талаар албан бичиг хүргүүлж, улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудлын арын талбайд тамхи татах 3 цэгийг

Гэмт хэрэг ихээр үйлдэгдэх магадлалтай Улаанбаатар зорчигч үйлчилгээний төвд эргүүл хяналтыг сайжруулан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэгийг галт тэрэг ирэх, явах болон хөдөлгөөн ихтэй цагт 4-5 удаагийн давтамжтайгаар лавлахаар хэлүүлэн ажиллаж байна. Улаанбаатар зорчигч

үйлчилгээний төв буудлын арын лед дэлгэц болон иргэдийн хүлээлгийн танхимд хууль сурталчлах болон насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэрэг болон бусад мэдээллийг иргэдэд хүргэхийн тулд санал хүсэлтийн хайрцагтай самбар хийлгэн, гэмт хэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай албан даалгаврын хүрээнд видео хэлбэрээр сэрэмжлүүлэгүүдийг бэлдэж иргэдийн хүлээлгийн танхимд 45 минутын давтамжтайгаар үзүүлэн ажиллаж байна.

Суудлын галт тэргээр зорчигчдыг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлж видео шторкыг тогтмол явуулж байхаар улаанбаатар төмөр замын зорчигч үйлчилгээний албаны дарга Пүрэвсүрэнд хүргүүлсэн.

Мөн Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудлын өндөрлөсөн давцан болон арын талбайд байрлах хогийн саван дээр тамхи татахыг хориглоно гэсэн 20 ширхэг санамжийг байршуулсан.

## Саатуулах байрны ажлын талаар

Саатуулах байр нь 2015 онд архидан согтуурч, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 2892 эмэгтэйг хүлээн авч саатуулсанаас 2834 хүнээс 11873550 төгрөгний төлбөр гаргуулан санхүүгийн албанд тушааж төлбөр төлөлт 97,9 %- тай байгаа нь өмнөх оныхоос саатуулагдсан хүний тоо 27,8%-аар буурсан, төлбөр төлөлт 12,2%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт албадан саатуулагдсан иргэдийн албадан хүргэгдэж ирсэн шалтгааныг тодруулбал:

1.Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан –1380

2. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ танхайрсан-295

3.Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож, гэмт хэрэг зөрчилд холбогдсон -322

4. Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон –895

Хаанаас хүргэгдэн ирсэн шалтгааныг тодруулбал:

1. Гудамж, талбай олон нийтийн газраас-806

2. Гэр орон сууц- 1170

3. байгууллага аж ахуйн нэгж- 98

4.үзвэр үйлчилгээний газраас-14

5.баар цэнгээний газраас- 254

6.зочид буудлаас-94

7. бусад газраас- 456 эмэгтэй иргэд тус тус хүргэгдэн ирж саатуулагдсан байна.

Асран хамгаалагчид нь 24 иргэнийг хүлээлгэн өгсөн.

Саатуулагдсан 2892 иргэдийн талаархи мэдээлэлийг ЦЕГ-ын Захиргааны тоо бүртгэлийн санд оруулж, хэлтсийн мэдээлэл судалгааны ахлах байцаагч цагдаагийн ахмад Ц.Сайханзоригтой 2892 иргэний мэдээлэлийг тулгаж, дугаар давхардсан, мэдээлэл дутуу шивэгдсэн зэрэг асуудлыг тухай бүрд нь засуулж, хяналт тавин ажилласан. Үүрэг гүйцэтгэж байгаа 8 цагдаагийн алба хаагчид саатуулах байранд саатуулагдах хугацаандаа ЦАХ-ийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй 764 иргэнийг ЗХТХ-ийн 30.2.1 зүйлээр 3820000 төгрөгөөр торгож, төлбөрийг тухай бүрт нь төрийн санд тушааж санхүүд тооцоо нийлж мэдээллийн санд шивж оруулсан байна.

Саатуулах байрны эмч, цагдаа нар АСАП сангаас эрэн сурвалж байсан 9 иргэнийг олж тогтоон холбогдох цагдаагийн хэлтэс, алба хаагчидад мэдэгдэн хүлээлгэн өгч эрэн сурвалжилтыг зогсоосон байна.

Саатуулах байранд хүргэгдэн ирж буй иргэдэд тавих хяналт шалгалтыг сайжруулснаар 3 иргэнээс хутга мэс хураан авч торгуулийн арга хэмжээ тооцон тушаасан байна.

Саатуулах байрны эмч цагдаа нарын ажлын үзүүлэлтийг сар тутам гарган оны эцсийн байдлаар ажил мэргэжлээрээ бусдыгаа хошуучлан ажилласан цагдаа цагдаагийн ахлах ахлагч Ч.ЦэндАюуш хэлтсийн ажил мэргэжлийн аваргаар тодорч шагнуулсан болно.

Саатуулагдсан иргэдийн картыг өдөр тутам авч төлбөр төлөлт хугацаандаа төлөгдсөн эсэх , саатуулагдсан иргэдэд зарцуулсан эм тарианы зарцуулалтыг тогтмол тооллого хийлгэн тайлан мэдээг сар болгон гарган санхүүд өгч тулган, санхүүжилтээр 200000 төгрөгний 18 нэр төрлийн эм тариа, хэрэгсэл орлогод авч ажилласан. Хугацаа дууссан 21 нэр төрлийн эмийн бүртгэл гарган устгалд оруулахаар бэлэн болгосон.

Хэлтсийн нийт бүрэлдэхүүн 2015 оны 10 дүгээр сар 01-ны байдлаар ээлжит эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 150 алба хаагч орсон буюу нийт алба хаагчийн 80,6 хувь хамрагдсан байна. Мөн цусны төвтэй хамтран алба хаагчдын цусны бүлэглэлийг тодорохойлуулсан

**Архидан согтуурахаас сэргийлэх ажлын хүрээнд:**

2015 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахаас сэргийлэх чиглэлээр “Хяналт шалгалт-10 сар” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж УБТЗ-ын харьяа “Ган Зам” зочид буудал, ресторан, “Тансаг” түрээсийн саун, Төмөр замын соёлын ордонд “Локомотив” түрээсийн караоке,Нийтийн хоолны харьяа УБ-Замын үүд чиглэлийн 103,104-р вагон ресторан, УБ Төв буудлын ресторан, түрээсийн “Азын таван заан” ХХК-ны кофе лоунж, төмөр зам дагуух Говьсүмбэр аймгийн Чойр,

Дорноговь аймгийн Сайншанд, Замын үүд дэх Аялал зуучлалын төвийн "Жинчин" зочид буудал, ресторан, Тээш худалдааны Төвийн харьяа Ган зам хүнсний дэлгүүрийн үйл ажиллагааг шалган илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар албан мэдэгдэл бичин, зөрчил арилгасан талаар хариу авсан.

Албадан эрүүлжүүлэгдсэн 2892 иргэний гар, хуруун хээ болон зургийг Шүүх шинжилгээний папилон санд оруулж бүртгэл судалгаанд хамруулан ажилласан.

2015 онд саатуулах байраар үйлчлүүлсэн 2892 иргэнд архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг, зөвлөмж 140 ширхэгийг тараан, "Архины хор нөлөө, эмэгтэйчүүдийг эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?" зэрэг 4 сэдвээр саатуулах байрны эмч нараар ярианы сэдэв бэлтгүүлэн өдөр бүр яриа таниулга хийж, эрүүл мэндийн зөвлөгөө болон хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

ТЗУГ-ын ГХСЗөвлөлтэй хийсэн гэрээний дагуу Мэдээлэл суртчилгааны галт тэрэг аяны хүрээнд төмөр зам дагуух 6 зангилаадын төмөр замчид, нутгийн ард, иргэд болон албан байгууллагууд хамрагдаж Говьсүмбэр аймгийн Чойр зангилаанд 100, Дорноговь аймгийн Сайншанд зангилаанд 128, Дорноговь аймгийн Замын-Үүд зангилаанд 324, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа зангилаанд 172, Дархан уул аймгийн Дархан зангилаанд 113, Дархан татах хэсгийн 42 төмөр замчдад, т Сэлэнгэ аймгийн Сүхбаатар зангилаанд 80, буюу нийт 1072 иргэнд СЭМҮТ-ийн их эмч Ж.Гантулга сургалт зохион байгуулан " Архи, тамхины хор хөнөөл", Архинд донтох эмгэг-Ажлийн байран дахь архидалт, Архинаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийн талаар сургалт орж, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг иргэдэд зааж, иргэдэд ганцаарчилсан зөвлөгөөг өгч ажилласан. СЭМҮТ-ийн эмч Г.Гантулгаар "Архины хор уршиг" сэдвээр хэлтсийн нийт бие бүрэлдэхүүн болон саатуулагдсан 3 иргэнд хичээл сургалт ганцаарчилсан зөвлөгөөг өгч ажилласан.

**Замын цагдаагийн албанаас:**

Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний дүрмийг хэрэгжүүлэх чиглэлээр тус цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн албанаас 2015 онд доорхи ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**Нэг:Осол зөрчлийн талаар**

2015 онд гудамж замд хуваарийн дагуу 3 офицер, 6 зохицуулагч ажиллаж нийт 11954зөрчил илрүүлж, зөрчил гаргасан 11858хүнийг 179,903,200 төгрөгийн бэлэн бус хэлбэрээр торгож, ASAP сангаар эрэн сурвалжлагдаж байсан хүн 2,эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 168, согтуугаар автомашин жолоодсон 69зөрчил тус тус илрүүлэн 25 тээврийн хэрэгслийг түр саатуулж БГД-ийн замын цагдаагийн тасагт шилжүүлж ажиллаа.

Нийслэлийн Засаг даргын захирамжид заасны дагуу улсын дугаарын хязгаарлалтын хүрээнд хяналт шалгалт хийж нийт 2357 зөрчил илрүүлэн бэлэн бусаар

зөрчил гаргасан 2357 хүнийг 18,856,000 төгрөгөөр торгож ажлын өдрүүдэд хяналт тавьж ажилласан.

Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол мэдээлэл 156 хүлээн авчшалганшүүхээр баривчилсан 1,мэдээлэл тогтоогдоогүй 1, шалгаж шийтгэврээр 125 хүнийг 3,225,000 төгрөгөөр торгож,29 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэлээ.

Төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудлын авто зогсоол дээр гарсан зам тээврийн ослын дуудлага мэдээлэл 15 хүлээн авч ослын хохирлыг даатгалын байгууллагуудаар төлүүлж хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн.

2015 онд төмөр замын гармууд дээр 18 удаа зам тээврийн осол, хэрэг гарч, осол хэргийн улмаас 2 хүний амь нас хохирч, 2 хүний биед хөнгөн, хүндэвтэр гэмтэл учирч, иргэд, аж ахуй нэгж байгууллагад 155,926,884 мянган төгрөгийн хохиролучирсан байна. Осол хэргийн улмаас учирсан хохирлын 90% -ийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна. Гарсан зам тээврийн осол хэргийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад төмөр замын гарам дээр гарсан осол хэрэг 20 %-иар өссөн, нас баралт, гэмтсэн хүний тоо өсөлт, бууралтгүй байна.

## Хоёр: Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар:

Зам тээврийн гэмт хэрэг осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Замын цагдаагийн газар, аймгуудын цагдаагийн газар, хэлтэс, БГД-ийн замын цагдаагийн тасаг, Авто тээврийн үндэсний төв, Төмөр замын байгууллагуудтай хамтран “Автобусны зогсоол”,”Сар шинэ”,”Шинэ оны нар харах”,“Нийтийн тээвэр”, “Хурд-Хамгаалах бүс-мотоцикль”,“Техникийн бүрэн бүтэн байдал”,”Вокзал-1,2,3,4”,”Согтуу-1,2,3,4,5”,”Төмөр замын гарам” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж үр дүнг тооцож ажилласан.

Төмөр замын цэцэрлэгүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2015” тэмцээнийг зохион байгуулж, шалгарсан Төмөр замын “Ган зам” цэцэрлэг Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд орж тусгай байр эзэлж шагнагдсан .

Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Нийслэлийн ерөнхий боловсролын 28, 78 дугаар дунд сургууль, УБТЗ-ын хүүхдийн байгууллагын харъяа сурагчдын дотуур байрны 1-8 дугаар ангийн сурагчдад Замын хөдөлгөөнд хэрхэн оролцох вэ? сэдэвт 4 цагийн сургалт зохион байгуулж, сургалтанд 263 хүүхэд хамрагдсан.

Төмөр замын гарам дээр гарч байгаа зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, анхаарах зүйлийн талаарштатахуун тээврийн Петровис ХХК, Нийтийн тээврийн Автобус-1 ХК, Блюбус ХХК, Автобус-3, Тэнүүн дэлгэр, Эрдэм транс, Гацуурт, Хүннү конгрейт зэрэг байгууллагуудын жолооч нарт 11 цагийн сургалт зохион байгуулж, сургалтанд 798 хүн хамрагдсан.

Шинээр батлагдсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар цагдаагийн хэлтсийн офицер цагдаа нарт, Улаанбаатар төмөр замын Авто бааз, Улаанбаатар төмөр замын Дохиолол холбооны 2-р анги,Зам засварын машинт станц, Төмөр замын Замын 1, 2, 4, 6-р анги зэрэг байгууллагуудын жолооч нарт 12 цагийн сургалт зохион байгуулж, сургалтанд 631 жолооч хамрагдсан

Нийслэлийн Замын цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран MNC, Йигл телевизээр сэрэмжлүүлэг, 25-р суваг телевизтэй хамтран "Хүсээгүй дайн" нэвтрүүлгийг төмөр замын гарам дээр хийж, иргэд жолооч нарт төмөр замын гармыг аюулгүй нэвтрэх талаар сурталчилсан.

Замын цагдаагийн газрын фэйс бүүк, Авто радио FM 96.3-р иргэд жолооч нарт төмөр замын гарам нэвтрэх талаар сэрэмжлүүлэг хүргүүлсэн.

Төмөр замын авто тээвэр үйлчилгээний төв, Олон улсын галт тэрэгний тасалбар түгээх төв зэрэг байгууллагуудын алба хаагч, жолооч нарт цагдаагийн хэлтсийн 2014 онд хийсэн ажлын тайлан болон осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар яриа хийж санал хүсэлтийг авч ажилласан.

Улаанбаатар хотын Замын цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ч.Жаргалсайханаас өгсөн үүргийн дагуу Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудал орчмоос хөдөө орон нутагт зөвшөөрөлгүйгээр зорчигч тээвэрлэсэн 44 жолоочийн холбогдох бичиг баримтыг Авто тээврийн үндэсний төвд,3 жолоочийн бичиг баримтыг Нийслэлийн тээврийн газарт шийдвэрлүүлэхээр тоотоор хүргүүлж, Баянгол дүүргийн Замын цагдаагийн тасагт 71 жолоочийн бичиг баримтыг шилжүүлэн, 35 жолоочид дахин энэ төрлийн зөрчил гаргуулахгүй байх талаар сануулж баталгаа авч туслах тоо бүртгэлийн санд оруулж шийдвэрлэсэн.

Төмөр замын "Гармын мэдлэг дээшлүүлэх" олон улсын өдрийг төмөр замын 413-р км/ийн гарам дээр тэмдэглэн өнгөрүүлэхэд оролцож ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу Цагдаагийн хэлтсийн нийт алба хаагчдаас алба ба амины тээврийн хэрэгслийг согтуугаар жолоодохгүй байх талаар 3 удаа баталгаа авч ажилласан.

Төмөр замын цагдаагийн хэлтсийн хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарт ЦҮАЖ -ийн код 408 журмаар 1 цагийн зохион сургалт байгуулж, сургалтанд 12 алба хаагч хамрагдсан.

Улаанбаатар төмөр замын аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран Зам тээврийн ослоор хохирогсдод хүндэтгэл үзүүлэх өдрийг тохиолдуулан нээлттэй өдөр зохион байгуулан үр дүнг тооцож ажилласан.

Монгол улсын Замын хөдөлгөөний дүрмийн 14-р бүлэг төмөр замын гарам нэвтрэх талаар "**АНХААР ЗОГС ГАЛТ ТЭРЭГНЭЭС БОЛГООМЖИЛ**" зурагт хуудас 10,000 ширхэгийг хэвлүүлж, 2500 ширхэгийг иргэд жолооч нарт тарааж санал хүсэлтийг авч ажилласан.

Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 17 байгууллагад албан мэдэгдэл шаардлага өгч, 8 албан мэдэгдэлд хариу авч ажилласан.

Гурав: Замын зохион байгуулалтын талаар

Төмөр замын Дохиолол холбооны 2-р анги, Замын 2-р анги, ЗЦГ-ын Орон нутаг, Хурдны замын хяналтын хэлтэстэй хамтарч 2 удаа Төмөр замын гармуудын дохиолол, замын тэмдэг тэмдэглэлд үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчлийг засуулах талаар Улаанбаатар төмөр замын дарга болон Замын 2-р ангид актыг хүргүүлж ажилласан.

Төмөр замын зорчигч үйлчилгээний төв буудал, Авто тээвэр үйлчилгээний төв, Олон улсын галт тэрэгний тасалбар түгээх төв зэрэг байгууллагуудтай хамтран 4 удаа төмөр замын 28 байгууллагуудын харуул хамгаалалт, гэрэлтүүлэг, хяналтын камерийн ашиглалтад үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчлийг засуулж ажилласан.

Зам тээврийн яамны Зам тээврийн Хяналтын хэлтэс, Төмөр замын Хяналтын алба, Нийслэлийн Авто замын газар, Төмөр замын Замын 2-р ангитай хамтарч Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа Төмөр замын салбар 12 гармуудын хөдөлгөөний аюулгүй байдал, үзэгдэлт, дохиолол, замын тэмдэг тэмдэглэл, гармуудын гэрэлтүүлэг, өвөлжилтийн бэлтгэл хангасан байдлыг 2 удаа шалгаж, шалгалтаар илэрсэн зөрчлийг засуулах талаар төмөр замын хяналтын албанд саналаа хүргүүлж ажилласан.

Улаанбаатар төмөр замын Салхитын 157, Дархан-уул аймгийн төмөр замын 127, төмөр замын 406, 407 дугаар километрийн гармуудын Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр Төмөр замын Хяналтын албанд тоот хүргүүлсэн.

Хан-уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах төмөр замын ТЭЦ-3 гар ажиллагаатай жижүүртэй гарам, Сонгино хайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах НИК-ийн дохиололгүй тэмдгээр зохицуулагддаг гармуудыг автомат дохиолол, хаалттай болгох, камержуулах талаар салбар зам хариуцсан 3 дугаар цахилгаан станц, Петровис ХХК-ны холбогдох хүмүүст саналаа хүргүүлсэн.

УБТЗ-ын ЗҮТБ-ын арын 337 уулзварын гэрлэн дохионы давхцалд өөрчлөлт, зохицуулалт хийлгэхээр Замын хөдөлгөөний удирдлагын төвд албан тоот хүргүүлж шийдвэрлүүлсэн.

УБТЗ-ын ЗҮТБ-ын арын авто машины зогсоолын хэвтээ тэмдэглэлийг хийлгэж, шаардлагатай гарцууд дээр 3 ширхэг /Хориглох/ тэмдгүүд шинээр тавин байрлуулж, арын 330, 337 уулзварууд дээр дутуу байгаа 3 ширхэг /Заах/ замын тэмдгийн судалгааг гарган Замын цагдаагийн газрын Замын зохион байгуулалтын тасагт хүргүүлсэн.

Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Төмөр замын том холбохын дохиолoлтой гармыг жижүүртэй, автомат хаалттай, автомат саадаар тоноглож, камержуулж авто замын өргөтгөл болон тэмдэг тэмдэглэлийг хийлгүүлж байна.

Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Бараа баазын дохиололтой гарам дээр гармын дохиоллын үзэгдэлтийг сайжруулж өндөрлөсөн шонд дохиололыг тавиулсан.

Орхон аймгийн нутаг дэвсгэрт байрлах төмөр замын 165-р км-ийн жижүүртэй гармыг аймгийн Замын хөдөлгөөний удирдлагын төвийн сүлжээнд холбуулан камержуулж , галт тэрэгний ойртох хэсгийн дохиолол хэт хол, гармын дохиолол ажиллаж байхад тээврийн хэрэгслүүд маш их зөрчиж хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байсныгтөмөр замын байгууллагад саналаа хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Дархан-уул аймгийн нутаг дэвсгэрт байрлах төмөр замын 121-р км-ийн хамгаалалттай гарам дээр цацруулагчтай түмбэ байрлуулж замын хөдөлгөөний урсгалыг тусгаарласнаар уг гарам дээр гармын хаалтыг автомашин сүлжих явдал буурсан.

Дөрөв :Бусад ажлын талаар

ОХУ-ын Төрийн Думын дарга, Унгар улсын ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Болгар улсын ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Энэтхэг улсын ерөнхий сайд, Холбооны Бүгд Найрамдах Мьянмар улсын ерөнхийлөгч, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ерөнхийлөгч, Япон Улсын Ерөнхий сайд, Бүгд Найрамдах Солонгос Улын Ерөнхий сайд манай улсад төрийн айлчлал хийх үеийн А зэрэглэлийн хамгаалалт,Нийслэлийн Багахангай дүүрэгт зохиогдсон Шинэ оны нар харах, Сар шинэ,Үндэсний их баяр наадам, УБТЗ-ын Мэргэжлийн өдөрлөг зэрэг хамгаалалт зохицуулалтанд давхардсан тоогоор 3 офицер, 6 зохицуулагч ажиллаж, 571 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажилласан.

х/ч Г.Басбиш Ёс журмын эргүүлээр 1, Хэлтсийн ерөнхий эргүүлээр 41 удаа, Замын цагдаагийн газрын ерөнхий эргүүлээр 9 удаа гарч, УБТЗ-ын олон нийтийн эргүүлээр 2 удаа тус тус гарч, 19 алба хаагчид зааварчилгаа өгч, 17 алба хаагчид албаны шалгалт явуулж хэлтсийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлүүлсэн.

ЦЕГ, ЗЦГ, УБТЗ-аас ирүүлсэн албан бичиг тоот, үүрэг чиглэлийн дагуу хариу болон биелэлтийг тооцож цаг хугацаанд нь явуулж ажилласан.

ЗЦГ-ын Төв орон нутгийн цагдаагийн байгууллагын Замын цагдаагийн нэгжийн удирдах ажилтны зөвлөлгөөн, Төмөр замын удирдах газар дээр зохиогдсон Иргэдийн аюулгүй байдал, өнөөгийн тулгамдсан асуудал сэдэвт зөвлөлгөөнд замын цагдаагийн ахлах зохицуулагч х/ч Г.Басбиш оролцсон.

Төмөр замын гарам дээр гарсан осол хэргийн шийдвэрлэлт болон нөхцөл байдлын танилцуулгыг төмөр замын хяналтын алба болон замын ангиудад сар бүр тоотоор хүргүүлж ажилласан.

Төмөр зам дахь цагдаагийн хэлтсээс зохиогдсон болон мэргэжлийн хичээл сургалт, спортын уралдаан тэмцээн, явган аялал зэрэгт алба хаагчдыг бүрэн хамруулсан.

Тус цагдаагийн хэлтсийн сэтгэл зүйчийн хамт 6 алба хаагчийн ар гэрээр орж амьдрал ахуйтай нь танилцаж гаргасан санал хүсэлтийг нь хэлтсийн даргад танилцуулсан.

Байцаагч, зохицуулагч нар Сургалт дадлагын төв дээр зохиогдсон Зам тээврийн осол зөрчлийг шалгах сэдэвт мэргэшүүлэх сургалтанд хуваарийн дагуу хамрагдаж, санхүүтэй шийтгэврийн тооцоог тухай бүр хийж албаны сарын тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлэн ажиллаа.